



МУИС-ИЙН СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ 2025-2030

УЛААНБААТАР ХОТ

АГУУЛГА

ӨМНӨХ ҮГ	5
УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРАЛДААНЫ ТОГТООЛ.....	7
НЭГДҮГЭЭР БҮЛЭГ.	
МУИС-ИЙН 2025-2030 ОНЫ СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ҮНДЭСЛЭЛ, БАРИМТАЛСАН ЗАРЧИМ.....	9
ХОЁРДУГААР БҮЛЭГ.	
МУИС-ИЙН ӨНӨӨГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ, 2016-2024 ОНЫ СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙН ШИНЖИЛГЭЭ	13
2.1. МУИС-ИЙН ӨНӨӨГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ.....	13
2.2. МУИС-ИЙН 2016-2024 ОНЫ СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ	14
2.3. СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨГ ШИНЭЧЛЭХ ШААРДЛАГА	15
ГУРАВДУГААР БҮЛЭГ.	
МУИС-ИЙГ 2030 ОН ХҮРТЭЛ ХӨГЖҮҮЛЭХ СТРАТЕГИ, ЗОРИЛГО.....	17
ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ.	
СТРАТЕГИЙН ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ, ЗОРИЛГО, ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА	19
4.1. ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ 1. ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭ – Судалгаа, инновацын чадамжийг бэхжүүлнэ	19
4.2. ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ 2. СУРГАЛТ – Дэлхийд өрсөлдөх чадвартай оюунлаг иргэдийг бэлтгэнэ	25
4.3. ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ 3. НИЙГМИЙН ОРОЛЦОО– Хамтын ажиллагаагаар нийгэмд тогтвортой үнэ цэнийг бүтээнэ.....	30
4.4. ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ 4. НӨӨЦ - Байгууллагын нөөцийн оновчтой удирдлагыг хөгжүүлнэ.....	36
4.5. ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ 5. ЗАСАГЛАЛ - Сайн засаглалыг төлөвшүүлж, менежментийн чадамжийг бэхжүүлнэ	42
ТАВДУГААР БҮЛЭГ.	
ГҮЙЦЭТГЭЛИЙН ТҮЛХҮҮР ҮЗҮҮЛЭЛТ, ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА.....	49
5.1. ГҮЙЦЭТГЭЛИЙН ТҮЛХҮҮР ҮЗҮҮЛЭЛТ	49
5.2. ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА.....	51

ХАВСРАЛТ 1

МУИС-ийн 2025-2030 ОНЫ СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ

ГҮЙЦЭТГЭЛИЙН НИЙТ ҮЗҮҮЛЭЛТ.....57

ХАВСРАЛТ 2

ГҮЙЦЭТГЭЛИЙН ҮЗҮҮЛЭЛТИЙН ТАЙЛБАР.....63



ӨМНӨХ ҮГ

Манай улсын дээд боловсролын ууган голомт Монгол Улсын Их Сургуулийн эрдмийн хамт олон 2025-2030 онд их сургуулиа хөгжүүлэх тэргүүлэх чиглэл, алсын хараа, эрхэм зорилго, үнэт зүйлсээ шинэчлэн тодорхойлж, хөгжлийн шинэ үеийн гараанд ирлээ.

МУИС анх удаа дэлхийн их сургуулиудын чансаа тогтоодог нэр хүндтэй байгууллага Times Higher Education (THE)-ээр үнэлүүлэн “Дэлхийн их сургуулиудын эрэмбэ-2025” жагсаалтад 1501+, байгалийн шинжлэх ухааны чиглэлээр 1001+ байрыг эзэлсэн бол Азийн их сургуулиудын эрэмбэ-2025-д мөн анх удаа багтаж 601+ байрыг эзэлсэн нь манай сургуулийн сургалт, судалгааны чанарын үзүүлэлт төдийгүй Монгол Улсын дээд боловсролын хөгжлийн үнэлгээ гэж үзэж болох юм.

Бид их сургуулиа “Дэлхийн түвшний судалгааны их сургууль” болгох алсын харааг тодорхойлж, улмаар улс орны хөгжлийн бодлого, шийдвэрийг суурь судалгаагаар дэмжин ажиллаж, дэлхийн их сургуулиудын эрэмбэд багтсан амжилтаа ахиулж олон улсын өндөр түвшний эрдэм шинжилгээний ажлуудыг нэмэгдүүлэхэд онцгой анхаарч ажиллана.

Үндэсний тэргүүлэх их сургуулийн хувьд улс орны хөгжлийн зорилт, хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэд нийцүүлэн сургалтын хөтөлбөрөө шинэчлэн, сургалтын олон талт хэлбэрийг санал болгож, насан туршийн боловсролыг дэмжин, нийгэмд шинжлэх ухаанч, эерэг мэдээллийн урсгалыг нэмэгдүүлэх үүргээ эрчимжүүлнэ.

Дээд боловсролын хөгжлийн чиг хандлага хийгээд Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгүүдийн үзэл баримтлалд суурилсан энэхүү стратеги төлөвлөгөөг боловсруулахад МУИС-ийн нийт багш, ажилтан, суралцагч, төгсөгч, ажил олгогчдын төлөөлөл идэвхтэй оролцсоныг тэмдэглэн хэлэх нь зүйтэй.

МУИС-ийн хэтийн хөгжлийн суурь баримт бичиг болох “МУИС-ийн стратеги төлөвлөгөө 2025-2030”-д тусгасан тэргүүлэх чиглэл, түүнд хүрэх зорилгоо биелүүлэхэд МУИС-ийн эрдмийн хамт олны гишүүн бүрийн хүчин чармайлт нэн чухал билээ.

Эрдмийн хэт цахиваас Хөгжлийн гал бадармуй.

МУИС-ийн ректор, профессор Б.Очирхуяг



МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛИЙН
УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРАЛДААНЫ
ТОГТООЛ

2024 оны 12 сарын 27 өдөр

Дугаар 27

Улаанбаатар хот

Стратеги төлөвлөгөө батлах тухай

Боловсролын ерөнхий хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1 дэх заалт, Дээд боловсролын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.1 дэх хэсэг, МУИС-ийн Удирдах зөвлөлийн дүрмийн 3.3, 3.4, 4.1.1 дэх заалт, МУИС-ийн дүрмийн 5.2.3.1 дэх заалт, МУИС-ийн Удирдах зөвлөлийн 2024 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Монгол Улсын их сургуулийн Стратеги төлөвлөгөө 2025-2030”-г дэмжин баталсугай.

2. Стратеги төлөвлөгөөний тэргүүлэх чиглэл, зорилго, зорилтууд болон үйл ажиллагааны төлөвлөгөөг МУИС-ийн жил бүрийн ажлын төлөвлөгөө, хөтөлбөрүүдэд тусган, гүйцэтгэлийн хяналтыг зохион байгуулж стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлэх бүхий л арга хэмжээг авч ажиллахыг ректор (Б.Очирхуяг)-т үүрэг болгосугай.

ДАРГА



Х.БАТЖАРГАЛ

МУИС-ИЙН 2025-2030 ОНЫ СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ҮНДЭСЛЭЛ, БАРИМТАЛСАН ЗАРЧИМ

Дэлхийн тэргүүлэх их сургуулиуд нь тогтвортой хөгжил, байгаль дэлхийд ээлтэй хандлагыг чухалчилсан *ногоон их сургууль*; шинжлэх ухаан, технологийн дэвшлийг боловсрол, судалгаа шинжилгээнд нэвтрүүлсэн *ухаалаг/ дижитал их сургууль*; олон соёлыг хүлээн зөвшөөрч, дэлхий нийтийн боловсролоор ялгардаг *глобал их сургууль*; шинжлэх ухааны нээлт, инновацыг дэмжиж, мэдлэг бүтээх, түгээх замаар улс орны хөгжилд далайцтай хувь нэмэр оруулдаг *судалгааны их сургууль*; инновац, гарааны компанийн соёлыг дэмжин хөгжүүлдэг *энтрепренёр их сургууль*; нийгмийн шударга ёс, тэгш байдал, оролцоог чухалчилж, нийгэмд эерэг нөлөө үзүүлдэг *нийгэмд нөлөөлөгч их сургууль* болох зэргээр бусдаас ялгарах зорилгоо тодорхойлон хөгжиж байна.

МУИС-ийг 2025-2030 онд хөгжүүлэх стратеги төлөвлөгөөг Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого “Алсын хараа 2050”, Дунд хугацааны зорилтот хөтөлбөр “Шинэ сэргэлтийн бодлого”, дэлхий нийтийн сайн сайхны төлөөх “Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030” зэрэг баримт бичгийн үндсэн үзэл санаа, дэвшүүлсэн зорилготой уялдуулж боловсруулав.

УИХ-аас баталсан боловсролын багц хуулийн шинэчлэлийн агуулга, Дээд боловсролын тухай хуулийн зорилго, зарчим; боловсролын салбарын хөгжлийн дунд хугацааны төлөвлөгөө болон боловсролын асуудал эрхэлсэн яамны бодлого, үйл ажиллагаанд онцлон тусгасан улсын хөгжлийн хэрэгцээ шаардлагад нийцсэн боловсрол олгох; судалгааны их сургуультай болох, олон нийтэд хандсан нээлттэй боловсрол, насан туршийн суралцахуй, цахим сургалтыг дэмжих, улсдаа төдийгүй дэлхийд хүлээн зөвшөөрөгдсөн мэргэжилтэн бэлтгэх зорилт, үйл ажиллагааг стратеги төлөвлөгөө боловсруулахад чухалчлан үзэв.



МУИС нь 2023 онд БШУЯ-наас боловсруулан гүйцэтгэсэн дээд боловсролын сургалтын байгууллагын үндэсний эрэмбээр тэргүүн байрт жагсаж, сургалт 94%, эрдэм шинжилгээ 91%, гадаад харилцаа 41%, орчин үйлчилгээ 73%-р үнэлэгдсэн юм. Энэхүү үнэлгээ нь МУИС-ийн сургалт, эрдэм шинжилгээ үндэсний хэмжээнд зохих түвшинд хүрч, шаардлага хангасныг баталгаажуулсан боловч гадаад харилцаа, орчин үйлчилгээг сайжруулахад анхаарч ажиллах шаардлагатайг илтгэж байна.

Сүүлийн жилүүдэд МУИС-ийн эрдэм шинжилгээний өгүүлэл болон эшлэлийн тоо, номын сангийн хүртээмж, сурах бичиг, магадлан итгэмжлэгдсэн хөтөлбөрийн тоо, төгсөгчдийн ажил эрхлэлт, интернэтийн хүртээмж, мэдээлэл технологийн дэд бүтэц зэрэг үзүүлэлтэд ахиц гарч, сайжирсан болно. Гэвч хамтарсан хөтөлбөрийн тоо, үйлдвэрлэлтэй хамтарсан эрдэм шинжилгээний бүтээл, гадаад багш ба гадаад суралцагчийн хувийн жин, англи хэлээрх хөтөлбөр болон хичээлийн тоо, сургалтын төлбөрийн бус орлогын хэмжээ зэрэг стратегийн түлхүүр үзүүлэлт хангалттай хэмжээнд хүрээгүй байгааг анхаарах хэрэгтэй байна.

МУИС-ийг 2025-2030 онд хөгжүүлэх стратеги төлөвлөгөөг боловсруулахад дээд боловсролын хөгжлийн дэлхийн чиг хандлага, Монгол Улсын хөгжлийн бодлого “Алсын хараа 2050”, Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030, дээд боловсролыг зохицуулах хууль эрх зүйн баримт бичгүүд, Times Higher Education эрэмбэ, МУИС-ийн нөхцөл байдлын шинжилгээ, оролцогч талын саналыг үндэслэл болгож, холбогдох судалгаа, шинжилгээний үр дүнг харгалзан боловсруулав (Зураг 1).

Зураг 1. МУИС-ийн стратеги төлөвлөгөөний үндэслэл





Үүнд:

- МУИС нь дэлхийн тэргүүлэх их сургуулиудын орчин үеийн хөгжлийн гол чиглэлийг баримжаалан нөхцөл байдлаа үнэлж, хиймэл оюун ухаан, их өгөгдөлд суурилсан *дигитал их сургууль* руу тэмүүлэх; шинжлэх ухаан технологи, инновацын ололт амжилтыг эрхэмлэж, хүрээлэн буй орчинд ээлтэй сурах, ажиллах орчныг бүрдүүлсэн *судалгааны их сургууль* болох;
- “Алсын хараа 2050”-д заасан “Хүний хөгжил”-ийн бодлогын зорилт болох “олон улсын шаардлага хангасан дээд боловсролын сургалтын байгууллагын тоог нэмэгдүүлж, чанарыг дээшлүүлэн олон улсад эрэмбэлэгдсэн, хүлээн зөвшөөрөгдсөн хөтөлбөр бүхий *үндэсний судалгааны их сургуультай болох*” зорилтыг хэрэгжүүлэх;
- Монгол Улсын дээд боловсрол, шинжлэх ухааны салбарт түүчээлэгчийн хувьд Дээд боловсролын тухай хуулийн 6.1.3-ын “судалгаа, шинжилгээний ажил явуулах, инновац, технологи хөгжүүлэх” заалтыг баримтлан судалгааны ажлыг чанаржуулах, олон улсын түвшний судалгааны гарцыг нэмэгдүүлж, Монгол Улсын хөгжилд хувь нэмэр оруулах;
- Дэлхий даяар “Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030” баримт бичгийн зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагааг МУИС нь үүрэг хэмээн үзэж, их сургуульд нутагшуулах ажлын хүрээнд “Чанартай боловсролыг дэмжих”, “Жендерийн эрх тэгш байдлыг хангах”, “Хөгжлийн төлөөх түншлэлийг бэхжүүлэх” зэрэг зорилгыг хөгжлийн стратеги төлөвлөгөөнд тусгах;
- Дэлхийн их сургуулиудын зэрэглэлийг тогтоодог “*Times Higher Education World University Rankings 2025*”-д Монголын их сургуулиудаас анх удаа эрэмбэлэгдэж, дэлхийд чансаагаараа (1501+)-д жагссан амжилтыг бататгахын зэрэгцээ дараагийн 5 жилд “*Times Higher Education*”-н үзүүлэлтийн үнэлгээг өсгөхөд анхаарч, 100 байраар урагшлуулах зорилгыг тус тус дэвшүүллээ.



Стратегийн төлөвлөгөөг боловсруулахад баримталсан зарчмууд

1. Төлөвлөлтийн SMART зарчим

- Тодорхой (*Specific*): Стратегийн зорилго нь тодорхой, ойлгомжтой байх;
- Хэмжигдэхүйц (*Measurable*): Стратегийн зорилго бүрийг бодитойгоор хэмжих боломжтой үзүүлэлтийг тодорхойлох;
- Хүрч болохуйц (*Achievable*): Стратегийн зорилго бодитой, хүрч болохуйц байх;
- Бодит (*Realistic*): Стратегийн зорилго нь байгууллагын өнөөгийн чадамж, нөөц бололцоотой нийцэж, хэрэгжихүйц байх;
- Хугацаатай (*Timebound*): Зорилт тодорхой хугацаатай, хэрэгжилтийг хугацааны явцад дүгнэх боломжтой байх зарчмыг баримтлав.

2. Төлөвлөлтийн үйл явц ил тод, нээлттэй байх зарчим

Төлөвлөлтийн үйл явц сургуулийн оролцогч талуудад ил тод байх, мэдээлэл солилцох урсгал нээлттэй байх зарчмыг хэрэгжүүлэв.

3. Талуудын оролцоог бүрэн хангах зарчим

Багш, ажилтан, суралцагч, ахмад багш, ажилтан, төгсөгч, ажил олгогч, бодлого боловсруулагч зэрэг талуудын оролцоог бүрэн хангахыг зорив.

4. Нөхцөл байдал, суурь түвшний үнэлгээ бодитой байх зарчим

Сургуулийн өнөөгийн нөхцөл байдал, хүрсэн суурь түвшнийг бодитойгоор үнэлж, судалгаа шинжилгээний үр дүн, баримтад үндэслэн дүгнэлт гаргахыг чухалчлав.

МУИС-ИЙН ӨНӨӨГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ, 2016-2024 ОНЫ СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙН ШИНЖИЛГЭЭ

2.1. МУИС-ИЙН ӨНӨӨГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

МУИС нь өнөөгийн байдлаар 1600 багш, ажилтан, 23604 суралцагчтай, бакалаврын 168, магистрын 174 (мэргэжлийн, судалгааны), докторын 52 хөтөлбөрөөр сургалтын үйл ажиллагаа эрхэлж, нийт багшаас эрдмийн зэрэгтэй багш 59.7%, гадаад багш 3%-ийг эзэлж байна. Нийт суралцагчийн 71.7% нь бакалаврын, 28.3% нь ахисан түвшинд суралцдаг. МУИС-д гадаадын 17 улсын 316 иргэн бакалавр, магистр, доктор, монгол хэлний бэлтгэл хөтөлбөрт суралцаж байгаа бөгөөд үндэсний хэмжээнд магадлан итгэмжлэгдсэн хөтөлбөрийн нийт хөтөлбөрт эзлэх хувь 18.2% болно.

МУИС-ийн багш, судлаачид Web of Science JCR мэдээллийн системд бүртгэлтэй сэтгүүлүүдэд одоогоор 1700 гаруй эрдэм шинжилгээний бүтээл хэвлүүлж, тэдгээр эрдэм шинжилгээний бүтээлийн 70 гаруй хувь нь 21000 гаруй эшлэгдэн, нэг бүтээлийн дундаж эшлэл 12, МУИС-ийн *H*-индексийн үзүүлэлт 56 байна. Судалгааны ажлын 80 гаруй хувийг гадаадын судлаачидтай, 1.15%-ийг аж үйлдвэртэй, 5.3%-ийг дотоодын судлаачидтай, 4.7%-ийг МУИС-ийн судлаачид хамтран хэвлүүлжээ. Сүүлийн таван жилд Scopus-т бүртгэлтэй өгүүллийн тоо 1040, эшлэлийн тоо 5163 хүрчээ.

МУИС 2023-2024 оны хичээлийн жилд үндэсний болон хамтын ажиллагаатай гадаадын их, дээд сургууль, байгууллагатай хамтран 5.4 тэрбум төгрөгийн өртөг бүхий 155 судалгааны төсөл хэрэгжүүлж, судалгааны үр дүнгээр Web of Science өгүүллийн санд бүртгэлтэй 134 өгүүлэл хэвлүүлэв. Судалгааны ажил дахь суралцагчдын оролцоог дэмжиж, МУИС-ийн профессор багш нарын хэрэгжүүлж буй судалгааны төслийн санхүүжилтээс 193 судлаач оюутанд 206.4 сая төгрөгийн тэтгэлэг олгосон бөгөөд сургуулийн хэмжээгээр 54 патент, 7 гарааны компани, 5 инновацын бүтээгдэхүүн байна.



2024 онд МУИС-ийн харьяа судалгааны хүрээлэнгүүдээс Монгол судлалын хүрээлэн, Хот, бүс нутгийн хөгжлийн судалгааны хүрээлэн, Эдийн засгийн хүрээлэн Засгийн газрын тогтоолоор улсын төсвөөс санхүүжилт авахаар боллоо. Хүрээлэнгүүд гадаад, дотоодын байгууллагуудтай хамтын ажиллагааны хүрээнд 1.2 тэрбум төгрөгийн өртөгтэй 30 гаруй төсөл хэрэгжүүлж байна.

МУИС нь дэлхийн 45 улсын 470 гаруй байгууллагатай 304 хүчинтэй гэрээ, санамж бичгийн хүрээнд хамтран ажиллаж байгаагийн 85% нь их, дээд сургууль, эрдэм шинжилгээний байгууллага байна.

Сургалтын бус орлогын нийт орлогод эзлэх хувь 21.5%, нэг багшид ноогдох үйлдвэр аж ахуйн нэгжийн санхүүжилттэй судалгааны орлого 2.3 сая төгрөг, судалгаа инновацын ажилд зарцуулж буй төсвийн нийт төсөвт эзлэх хувь 5.8% байна. Профессор багш, ажилтны сарын дундаж цалин 800 ам.доллар орчим байна.

2.2. МУИС-ИЙН 2016-2024 ОНЫ СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ

МУИС-ийн 2016-2024 оны стратеги төлөвлөгөө бол “*либерал арт*”-ыг нутагшуулах, зах зээлийн тогтолцоон дахь өөрчлөлтөд дасан зохицоход чиглэсэн стратеги төлөвлөгөө байв. Энэхүү стратеги төлөвлөгөөг боловсруулахад төгсөгч, ажил олгогч, бодлого боловсруулагч, багш, ажилтан, суралцагч зэрэг холбогдох талын оролцоог хангах, хүрсэн түвшнийг бодитойгоор үнэлж, хэмжих; өмнөх стратегийн төлөвлөгөөний хэрэгжилтийг дүгнэх, дэлхийн их сургуулиудын эрэмбийг тодорхойлдог байгууллагуудын ашигладаг үзүүлэлтийг боломжит хэмжээнд тусгах, хэмжих үзүүлэлтийг алба нэгж, бүрэлдэхүүн/салбар сургууль, тэнхимийн түвшинд буулгах, МУИС-ийн түвшинд жил бүр ахиц дэвшлийг хэмжих 15 гүйцэтгэлийн түлхүүр үзүүлэлтийг боловсруулах, стратегийн зорилтуудад хүрч буй эсэхийг нарийвчлан хэмжих үзүүлэлтийг МУИС, түүний алба нэгж, бүрэлдэхүүн/салбар сургууль, тэнхимийн түвшинд тодорхойлж, хүрсэн түвшин, 2024 онд хүрэх түвшин, завсрын зорилтыг үзүүлэлт бүрээр гаргах, стратегийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх ерөнхий төлөвлөгөөг тусад нь боловсруулж, санхүүгийн тооцоог хийх гэсэн зарчмыг баримталсан байна.

2016-2024 оны стратеги төлөвлөгөөний нөхцөл байдлын үнэлгээгээр нэгдүгээрт, энэхүү төлөвлөгөө дээрээс доошоо чиглэлтэй байсан бөгөөд бүрэлдэхүүн сургууль болон тэдгээрийн тэнхим, анхан шатны нэгж хүртэл уялдаж чадаагүй; хоёрдугаарт, энэхүү төлөвлөгөөний тэргүүлэх чиглэл, зорилго, зорилтыг хэрэгжүүлэх санхүүжилтийн бүтэц тодорхой бус байв. Үүний нэг үр дагавар нь МУИС өрсөлдөх давуу талаа онцлоогүй;

Санхүүжилтийн эх үүсвэр татах менежмент сул байсан; Мэдээллийн олон систем ажиллаж байгаа боловч интеграци хийгээгүйн улмаас зорилго, зорилтын хяналт шинжилгээ, үнэлгээ тодорхойгүй болсон; Стратегийн тэргүүлэх чиглэл, зорилго, зорилтыг хэрэгжүүлэхэд хугацаа шаардлагатай байсан тул 2024 он гэхэд “хүрэхэд хүндрэлтэй” гэж үнэлэгдэв.

2016-2024 оны стратеги төлөвлөгөөний хэрэгжилтийг нэгтгэн дүгнэвэл, нийт 65 зорилтоос 73.8 хувийн биелэлттэй байна. Үүнээс эрдэм шинжилгээ, судалгааны 17 зорилт 66.7 хувь; сургалтын 27 зорилт 74.1 хувь; нийгмийн үйлчилгээний 8 зорилт 100 хувь; байгууллагын засаглалын 15 зорилт 86.7 хувийн гүйцэтгэлтэй байна.

2.3. СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨГ ШИНЭЧЛЭХ ШААРДЛАГА

МУИС нь аж үйлдвэрийн 4 ба 5 дахь хувьсгалын өөрчлөлт, улс хоорондох ажиллах хүчний шилжилт, залуу үеийн ажил мэргэжлийн сонирхол, Монгол Улсын хүн амын өсөлт, хөдөлмөрийн оролцоо, хөдөлмөрийн бүтээмжийг тасралтгүй дээшлүүлэх шаардлага зэрэг гадаад болон дотоод хүчин зүйлийн улмаас өрсөлдөх давуу тал, стратегиа шинэчлэх шаардлагатай байна.

- Нийгмийн талаас, “шинэ мэдлэг, дижитал хэрэглээ”-ний түвшнийг ахиулах;
- Улс төрийн талаас, дэлхийн дээд боловсролын зах зээлд хандах хандлагыг харгалзах;
- Технологийн талаас, салбаруудын харилцаа хамаарал, ач холбогдлыг уялдуулах, блокчейн, хиймэл оюун ухаан, AR/VR гэх мэт хэрэгслийн ухаалаг хэрэглээ рүү шилжих;
- Эдийн засаг талаас, Азийн орнуудын эдийн засгийн өсөлт хөгжил, бүс нутгийн интеграцид нэгдэх;
- Байгаль орчин талаас, ирээдүйд нүүрс хүчлийн хийн хэмжээг бууруулах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох зэрэг нэгдмэл, цогц стратегийн байр суурьтай болох шаардлагатай юм.

Иймд хамтарсан судалгааны үнэ цэн (*value driven*), салбар дундын судалгааг хамтарч хийх өндөр түвшний судалгааны багийг дотоод болон гадаад санхүүжилтээр дэмжих сорилтын үнэ цэн (*challenge driven*), дээд боловсролын өрсөлдөөнд өөрийн байр суурийг тогтвортой байлгахын төлөөх стратеги (*mission driven*) зэрэг эрсдэл, боломжийг дахин үнэлэх, дээд боловсролын хөгжлийн холч харааг зөв онилох, МУИС-ийн амжилтын гол хүчин зүйлст тулгуурлах, дээд боловсролын үйлчилгээний өвөрмөц үнэ цэнийг тодорхойлох, хөдөлмөрийн зах зээлийн хөгжлийн боломжийг нухацтай авч үзэх хэрэгтэй болсон байна.



МУИС нь Монгол Улсын хөгжлийг түүчээлэх үүрэгтэй эрдмийн байгууллагын хувьд дэлхийн улс орнуудын дээд боловсролын салбарт өрсөлдөх, шинжлэх ухааны судалгаа, хөгжүүлэлт, боловсруулалт, дамжуулалтад эзлэх байр сууриа улам бэхжүүлэх шаардлагатай байна.

МУИС мэдлэгийн болон дижитал эдийн засаг руу шилжих Монголын дээд боловсролын стратегийн зорилттой уялдуулж, “Судалгааны их сургууль” болох чиг хандлага руу шилжиж байна. Энэ ажлын хүрээнд байгууллагын засаглалын тогтолцоог оновчтой болгосноор их сургуулийн өрсөлдөх чадвар дээшилж, судалгаа болон сургалт сайжирна.

2016-2024 оны стратеги төлөвлөгөөний санхүүжилтийн хэрэгжилтээс дүгнэхэд санхүүгийн орлогын хэмжээ болон хөрөнгө оруулалтын үр өгөөжийг тасралтгүй нэмэгдүүлэх санхүүгийн менежментийн бүтэц нэн чухал юм. Ийм санхүүгийн менежментийн бүтцэд МУИС-ийн урт хугацааны хөрөнгө оруулалтын үр өгөөжийг өсгөх, эрдэм шинжилгээ, судалгааны эрэлтийг тодорхойлж, хөрөнгө оруулалтыг татан төвлөрүүлэх, орлого ба зарлагын мөнгөн урсгал, санхүүгийн эрсдэлийн удирдлагын чиг үүргийг хэрэгжүүлэх зохицуулалт шаардлагатай байна.

МУИС-ИЙГ 2030 ОН ХҮРТЭЛ ХӨГЖҮҮЛЭХ СТРАТЕГИ, ЗОРИЛГО

Алсын хараа - Дэлхийн түвшний судалгааны их сургууль болно.

Эрхэм зорилго - Бид шинжлэх ухааны хөгжлийн үндэсний түүчээлэгчийн хувьд эрдэм шинжилгээ, сургалтаар манлайлж, нийгмийг хөгжүүлэгч хүч болсон тэргүүлэх их сургууль байна.

Стратегийн тэргүүлэх чиглэл

Алсын хараа, эрхэм зорилгодоо хүрэх стратегийн тэргүүлэх таван чиглэлийг тодорхойллоо. Үүнд:

ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ 1. ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭ – Судалгаа, инновацын чадамжийг бэхжүүлнэ.

ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ 2. СУРГАЛТ – Дэлхийд өрсөлдөх чадвартай оюунлаг иргэдийг бэлтгэнэ.

ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ 3. НИЙГМИЙН ОРОЛЦОО – Хамтын ажиллагаагаар нийгэмд тогтвортой үнэ цэнийг бүтээнэ.

ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ 4. НӨӨЦ – Байгууллагын нөөцийн оновчтой удирдлагыг хөгжүүлнэ.

ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ 5. ЗАСАГЛАЛ – Сайн засаглалыг төлөвшүүлж, менежментийн чадамжийг бэхжүүлнэ.

Үнэт зүйлс:

- ✓ **Академик эрх чөлөө** – оюуны чөлөөт, нээлттэй эрэл хайгуул хийх, түүний үр дүнг чөлөөтэй илэрхийлэхийг бүх талаар дэмжиж, шүүмжлэлт сэтгэлгээг хөгжүүлэх;
- ✓ **Ёс зүй** – багш, судлаач, суралцагчийн болон хувь хүний ёс зүйг дээдлэн, үнэнч шударга байж, бусдад хүндэтгэлтэй хандах;
- ✓ **Уламжлалын бахархал** – дээд боловсролын анхдагч, шинжлэх ухааны суурь салбарыг хөгжүүлэгч, улс орны хөгжилд хувь нэмрээ оруулагч МУИС-аар овоглосон хэн бүхний бахархлыг бадраах;
- ✓ **Бүтээлч байдал** – бүтээлч сэтгэлгээгээр инновацлаг шийдэл, өөрчлөлтийг дэмжин, үр дүнд төвлөрч бүтээмжтэй ажиллах.

Уриа үг - Эрдмийн хэт цахиваас Хөгжлийн гал бадармуй.



Зураг 2. МУИС-ийн 2025-2030 оны стратегийн тэргүүлэх чиглэл, зорилгууд

Уриа үг		Эрдмийн хэт цахиваас Хөгжлийн гал бадармуй												
Үнэт зүйлс		Академик эрх чөлөө, Ёс зүй, Уламжлалын бахархал, Бүтээлч байдал												
Стратегийн зорилгууд		Стратегийг хянах гүйцэтгэлийн түлхүүр үзүүлэлт												
Эрхэм зорилго	Алсын хараа	ДЭЛХИЙН ТҮВШНИЙ СУДАЛГААНЫ ИХ СУРГУУЛЬ БОЛНО												
		Бид шинжлэх ухааны хөгжлийн үндэсний түүчээлэгчийн хувьд эрдэм шинжилгээ, сургалтаар манлайлж, нийгмийг хөгжүүлэгч хүч болсон тэргүүлэх их сургууль байна												
		Эрдэм шинжилгээ судалгаа, инновацын чадамжийг бэхжүүлнэ		Сургалт дэлхийд өрсөлдөх чадвартай оюунлаг иргэдийг бэлтгэнэ		нийгмийн оролцоо хамтын ажиллагаагаар нийгэмд тогтвортой үнэ цэнийг бүтээнэ		нөөц байгууллагын нөөцийн оновчтой удирдлагыг хөгжүүлнэ		Засаглал сайн засаглалыг төлөвшүүлж, менежментийн чадамжийг бэхжүүлнэ				
		Судалгаа, инновацын орчин нөхцөл, чадамжийг сайжруулна	Олон улсын өндөр түвшний эрдэм шинжилгээний ажлуудыг нэмэгдүүлнэ	Судалгаа, инновацаас олох орлогыг нэмэгдүүлнэ	Сургалтын олон талт хэлбэрийг өргөжүүлнэ	Нийгмийг хөгжүүлэгч тэргүүлэх судалгааны байгууллага байна	Нийгэмд зэрэг өөрчлөлтийг бий болгоход нөлөөлөх шинжлэх ухаанч, соён гэгээрүүлэгч, академик байгууллага байна	Тогтвортой хөгжлийг дэмжсэн, байгаль орчинд ээлтэй үйл ажиллагааны орчныг бүрдүүлнэ	Хүний нөөцийн бодлогоор авьяастны төвлөрлийг бий болгоно	Сурах, ажиллах, хөгжих таатай орчныг бүрдүүлнэ	Орлогын олон талт эх үүсвэрийг бүрдүүлж, үр ашигт чиглэсэн хөрөнгө оруулалтын тогтолцоог бий болгоно	Удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагааг олон улсын сайн засаглалын туршлагад нийцүүлнэ	Цахим засаглалыг хөгжүүлж, байгууллагын менежментийн чадамжийг бэхжүүлнэ	Стратегийн хэрэгжүүлэлтийн үйл явцыг боловсронгуй болгоно

СТРАТЕГИЙН ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ, ЗОРИЛГО, ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

4.1. ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ 1. ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭ – Судалгаа, инновацийн чадамжийг бэхжүүлнэ.

МУИС нь эрдэм шинжилгээ, судалгааны ажлаараа дотоодын их, дээд сургуулиудаа манлайлж ажилладгийн хувьд өнөөгийн байр сууриа бэхжүүлж, судалгаа, инновацийн чадамжийг нэмэгдүүлэхэд анхаарч ажиллана. Тиймээс стратеги төлөвлөгөөндөө дэлхийд хүлээн зөвшөөрөгдсөн судалгааны их сургууль болох алсын харааг дэвшүүлэв. Дотоод нөөц боломж, орчин нөхцөлийг бүрдүүлэн Times Higher Education (THE) байгууллагын дэлхийн шилдэг их, дээд сургуулийн эрэмбээ ахиулахад чиглэсэн судалгаа, инновацийн ажлын чанар, чансааг нэмэгдүүлэхэд зорьж ажиллах шаардлагатай байна. Төр, хувийн хэвшил, олон улсын байгууллагын санхүүжилтээр туршилт, судалгааны лабораториудыг шинээр байгуулах ажлыг хэрэгжүүлэхийн зэрэгцээ ашиглалтыг сайжруулахад анхаарч ажиллана.

Их сургуулийн хэмжээнд судалгаа шинжилгээг шинэ шатанд гаргахын тулд нэн түрүүнд хэрэгжүүлэх алхам нь МУИС-д судалгаа шинжилгээний чиглэлээр оруулсан орлого, хэрэгжүүлсэн төслийн үр дүнгээс хамаарч цалинждаг, цалин урамшуулал нь ажлын гүйцэтгэлтэйгээ шууд холбоотой, зах зээлийн зарчмаар ажилладаг, гүйцэтгэлд суурилсан менежментийг нэвтрүүлэхэд анхаарч ажиллана. Мөн МУИС-ийн харьяа судалгааны хүрээлэн, төвүүд багш, суралцагчдын оюуны бүтээлийг эдийн засгийн эргэлтэд оруулж, судалгаа, инновацийн орлогыг нэмэгдүүлэх шаардлагатай байна. Тиймээс судалгаа, инновацийн чадамжийг бэхжүүлэх тэргүүлэх чиглэлийн хүрээнд дараах зорилгыг дэвшүүлэв. Үүнд:

Зорилго 1.1. Судалгаа, инновацийн орчин нөхцөл, чадамжийг сайжруулна.

Зорилго 1.2. Олон улсын өндөр түвшний эрдэм шинжилгээний ажлуудыг нэмэгдүүлнэ.

Зорилго 1.3. Судалгаа, инновацаас олох орлогыг нэмэгдүүлнэ.

**Зорилго 1.1. Судалгаа, инновацын орчин нөхцөл, чадамжийг сайжруулна**

МУИС-ийн эрдмийн хамт олны судалгаа, инновацын чадамжийг сайжруулахын тулд олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн сэтгүүлтэй болохоос гадна эрдмийн зэрэгтэй багш нарын хувийн жинг 70 хувьд хүргэж нэмэгдүүлэх, пост-доктор судлаачийн тоог нэмэгдүүлэх бодлогыг баримталж ажиллана. Шинжлэх ухааны парк болон бусад туршилт судалгааны лабораториудад хэрэгжүүлсэн судалгааны ажлын үр дүнг эдийн засгийн эргэлтэд оруулах замаар судалгаа шинжилгээний ажлыг дэмжих хөрөнгө санхүүгийн эх үүсвэрийг бүрдүүлэхийн зэрэгцээ гарааны компани байгуулах эрх зүйн орчныг бүрдүүлж, судалгаа хөгжүүлэлтийн ажил хийх материаллаг орчин нөхцөлийг сайжруулна. Тухайлбал, судалгаа, инновацын орчин нөхцөлийг сайжруулахын тулд материаллаг бааз болох судалгааны лабораторийг нэмэгдүүлэхэд анхаарч ажиллана.

Хүснэгт 1. Зорилго 1.1-г хэрэгжүүлэх стратеги, хүрэх үр дүн

ХЭРЭГЖҮҮЛЭХ СТРАТЕГИ	ХҮРЭХ ҮР ДҮН
1.1.1. Судалгааны их сургуулийн статустай болох	✓ Төрийн бодлогын хүрээнд эрх зүйн хувьд баталгаажсан судалгааны их сургууль болсон байна.
1.1.2. WoS, Scopus-т бүртгэлтэй сэтгүүлтэй болох	✓ WoS, Scopus-т бүртгэлтэй 2-оос доошгүй сэтгүүлтэй болно. ✓ WoS, Scopus-т бүртгэлтэй МУИС-ийн сэтгүүлүүдийг дэмжих бодлого хэрэгжүүлнэ.
1.1.3. Эрдмийн зэрэгтэй багш нарын тоог нэмэгдүүлэх	✓ Эрдмийн зэрэгтэй багш нарын тоо 70 хувьд хүрнэ.
1.1.4. Судалгаа, инновацын ажилд зарцуулж буй төсвийг нэмэгдүүлэх	✓ Судалгаа, инновацын ажилд зарцуулж буй санхүүжилтийг нийт төсвийн 9 хувьд хүргэнэ.
1.1.5. Ахисан түвшний суралцагчдын төсөл, хөтөлбөр, судалгааны ажилд оролцох оролцоог нэмэгдүүлэх	✓ Судалгааны төсөл, хөтөлбөрт оролцсон докторант болон судалгааны магистрантуудын тоог нийт ахисан түвшний суралцагчийн 10 хувьд хүргэнэ.
1.1.6. Пост-доктороор ажиллах судлаачийн тоог нэмэгдүүлэх	✓ МУИС-д ажиллах гадаад ба дотоод пост-доктор судлаачийн тоо 30-д хүрнэ.
1.1.7. Багш, суралцагчдын оюуны бүтээлийн тоог нэмэгдүүлэх	✓ Гарааны компанийн тоо 20, патентын тоо 70, инновацын бүтээгдэхүүний тоо 30, технологийн зүгшрүүлэлт хийсэн бүтээгдэхүүний тоо 10-д хүрнэ.

1.1.8. Судалгааны орчин нөхцөлийг сайжруулах	✓ Судалгааны лабораторийн тоог 65-д хүргэнэ. ✓ Магадлан итгэмжлэгдсэн лабораторийн тоо 2-оос доошгүй болно.
1.1.9. МУИС-ийн Шинжлэх ухаан технологийн Улаанбаатар паркийг хөгжүүлэх замаар инновацын экосистемийг төлөвшүүлэх	✓ Технологи зүгшрүүлэлт, хагас үйлдвэрлэлийн цехийн тусламжтайгаар 2-оос доошгүй бүтээгдэхүүнийг зах зээлд нийлүүлнэ. ✓ Технологи зүгшрүүлэлт, бизнес хөгжүүлэлт хийж оюуны өмчийг эргэлтэд оруулна.
1.1.10. Судалгаа, инновацын чиглэлийн мэдээллийн системийн дэд бүтцийг бүрдүүлэх, сайжруулах	✓ Судалгаа, инновацын өгөгдлийн бодлоготой болсон байна. ✓ МУИС-ийн багш, суралцагчдын эрдэм шинжилгээний өгөгдлийг бүртгэлжүүлж, үйл ажиллагаандаа бүрэн хэрэглэдэг болно.

ГҮЙЦЭТГЭЛИЙН ТҮЛХҮҮР ҮЗҮҮЛЭЛТ

- WoS, Scopus-т бүртгэлтэй 2-оос доошгүй сэтгүүлтэй болно.
- Эрдмийн зэрэгтэй багш нарын тоог 70 хувьд хүргэнэ.
- Нийт төсөвт судалгаа, инновацын санхүүжилтийн эзлэх хэмжээг 9 хувьд хүргэнэ.
- МУИС-д ажиллах гадаад ба дотоод пост-доктор судлаачийн тоог 30-д хүргэнэ.
- Амжилттай гарааны компанийн тоо 20, патентын тоо 70, инновацын бүтээгдэхүүний тоо 30, технологийн зүгшрүүлэлт хийсэн бүтээгдэхүүний тоог 10-д хүргэнэ.
- Судалгааны лабораторийн тоог 65-д хүргэнэ.
- Магадлан итгэмжлэгдсэн лабораторийн тоо 2-оос багагүй болно.

Зорилго 1.2. Олон улсын өндөр түвшний эрдэм шинжилгээний ажлуудыг нэмэгдүүлнэ

Times Higher Education их дээд сургуулиудын зэрэглэл тогтоодог байгууллагад жил бүр өгөгдөл мэдээллийг өгөхөөс гадна судалгааны орчин, судалгаа, инновацын шалгуур үзүүлэлтүүдийн үнэлгээг сайжруулах зорилгоор олон улсын өндөр зэрэглэлтэй сэтгүүлд хэвлүүлэх өгүүллийн тоог нэмэгдүүлэхэд анхаарах болно.

Эрдэм шинжилгээний гадаад, дотоод хамтын ажиллагааны хүрээг өргөжүүлэх замаар хамтарч төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх, олон улсын



өндөр зэрэглэлтэй сэтгүүлд өгүүлэл хэвлүүлэх, голлох зохиогч МУИС-ийн харьяалалтай байх зэрэгт анхаарна. Мөн магистр, докторын түвшинд суралцагчдыг судалгаа, инновацын ажилд оролцуулах, хамтран судалгаа шинжилгээний ажил хийх, WoS, Scopus-т бүртгэлтэй өгүүлэл бичиж хэвлүүлэхэд тал бүрээр дэмжиж ажиллана.

Хүснэгт 2. Зорилго 1.2-г хэрэгжүүлэх стратеги, хүрэх үр дүн

ХЭРЭГЖҮҮЛЭХ СТРАТЕГИ	ХҮРЭХ ҮР ДҮН
1.2.1. Өндөр зэрэглэлтэй эрдэм шинжилгээний бүтээлийн хүрсэн түвшнийг ахиулах	✓ WoS, Scopus-т бүртгэлтэй сэтгүүлд хэвлүүлсэн өгүүллийн тоог 1500-д хүргэнэ. ✓ WoS, Scopus-ын Q1-Q2 зэрэглэлийн сэтгүүлд хэвлүүлсэн өгүүллийн тоог 180-д хүргэнэ. ✓ WoS, Scopus-т хэвлүүлсэн өгүүллийн эшлэлийн тоог 60 хувиар нэмэгдүүлнэ. ✓ Нэг багшид ногдох WoS, Scopus-ын эшлэлийн тоог 60 хувиар нэмэгдүүлнэ. ✓ Голлох зохиогч нь МУИС-ийн харьяалалтай байх өгүүллийг 50 хувьд хүргэнэ.
1.2.2. Үйлдвэр, аж ахуйн нэгжүүдтэй хамтарсан судалгаа, инновацын ажил гүйцэтгэх	✓ Үйлдвэр, аж ахуйн нэгжүүдтэй хамтарсан WoS, Scopus-т бүртгэлтэй өгүүллийн тоог нийт WoS, Scopus-т бүртгэлтэй сэтгүүлд хэвлүүлсэн өгүүллийн 3%-д хүргэнэ.
1.2.3. Салбар дундын болон гадаадын судлаачидтай хамтран тухайн салбарын дунджаас дээгүүр эрэмбэтэй сэтгүүлд хэвлүүлэх өгүүллийн тоог нэмэгдүүлэх	✓ Салбар дундын болон гадаадын судлаачидтай хамтран тухайн салбарын дунджаас дээгүүр эрэмбэтэй сэтгүүлд хэвлүүлсэн өгүүллийн тоог 300-д хүргэнэ.
1.2.4. Ахисан түвшний суралцагчдын хэвлүүлсэн өгүүллийн тоог нэмэгдүүлэх	✓ Ахисан түвшний суралцагчдын WoS, Scopus-т бүртгэлтэй өгүүллийн тоог 200-д хүргэнэ. ✓ Ахисан түвшний суралцагчдыг судалгаа, инновацын ажилд татан оролцуулах замаар дэмжиж идэвхжүүлэх зорилтот хөтөлбөр хэрэгжүүлнэ.

ГҮЙЦЭТГЭЛИЙН ТҮЛХҮҮР ҮЗҮҮЛЭЛТ

- WoS, Scopus-т бүртгэлтэй сэтгүүлд хэвлүүлсэн өгүүллийн тоог сүүлийн 5 жилийн нийлбэрээр 1500-д хүргэнэ.
- WoS, Scopus-ын Q1-Q2 зэрэглэлийн сэтгүүлд хэвлүүлсэн өгүүллийн тоог 180-д хүргэнэ.
- WoS, Scopus-т хэвлүүлсэн өгүүллийн эшлэлийн тоог 60 хувиар нэмэгдүүлнэ.
- Нэг багшид ногдох WoS, Scopus-ын эшлэлийн тоог 60 хувиар нэмэгдүүлнэ.
- Голлох зохиогч нь МУИС-ийн харьяалалтай байх өгүүллийн нийт өгүүлэлд эзлэх хувь 50-д хүрнэ.
- Салбар дундын болон гадаадын судлаачидтай хамтран тухайн салбарын дунджаас дээгүүр эрэмбэтэй сэтгүүлд хэвлүүлсэн өгүүллийн тоог 300-д хүргэнэ.
- Ахисан түвшний суралцагчдын WoS, Scopus-т бүртгэлтэй өгүүллийн тоог 200-д хүргэнэ.

Зорилго 1.3. Судалгаа, инновацаас олох орлогыг нэмэгдүүлнэ

2023 оны байдлаар төслийн санхүүжилтийн хэмжээ ойролцоогоор 4.7 тэрбумд хүрсэн ба 190 гаруй төслийг хэрэгжүүлсэн байна. Санхүүжилтийн эх үүсвэрийн төрлөөр нь авч үзвэл олон улсын болон гадаадын хамтарсан төслийн санхүүжилт хамгийн их хувийг буюу 40 хувийг, аж ахуйн нэгж байгууллагуудын санхүүжилт 30 хувь, шинжлэх ухаан, технологийн сангийн санхүүжилт 21 хувь, МУИС-ийн дотоод төсөл үлдсэн хувийг эзэлж байна. Бид энэхүү нөхцөл байдлыг өөрчилж, хүрэх үр дүнгээ 2030 он гэхэд нийт судалгаа шинжилгээнээс олох орлогыг 10 тэрбум төгрөгт хүргэж, улсын төсвөөс суурь судалгааны санхүүжилт авдаг болсноор санхүүгийн хувьд улам бэхжиж, судалгааны чанар, агуулга, хүрээ сайжирч, судалгаагаар дамжуулж нийгэмд хүргэх үнэ цэн өсөх юм.

Төрийн өмчийн их, дээд сургуулиудын эрдэм шинжилгээ, судалгааны зардал, тогтмол зардлыг Дээд боловсролын тухай хуулийн 32.2.2, 32.2.3 дахь зүйлд заасны дагуу төрөөс санхүүжүүлэх шийдвэр гарсан юм. Тус эрх зүйн орчны хүрээнд төрөөс авах судалгааны санхүүжилтийн талаар дотоодын бодлого боловсруулж хэрэгжүүлнэ.

**Хүснэгт 3. Зорилго 1.3-г хэрэгжүүлэх стратеги, хүрэх үр дүн**

ХЭРЭГЖҮҮЛЭХ СТРАТЕГИ	ХҮРЭХ ҮР ДҮН
1.3.1. Төр, хувийн хэвшлийн болон олон улсын байгууллагуудын дэмжлэгтэй төсөл, хөтөлбөр, судалгаа, эндаумент сан, инновацын орлогыг нэмэгдүүлэх	✓ Төсөл, хөтөлбөр, судалгаа, инновацын ажлаас 20 тэрбум төгрөгөөс багагүй орлого олно. ✓ Гадаадын санхүүжилттэй судалгааны орлогыг нэмэгдүүлж 8 тэрбум төгрөгт хүргэнэ. ✓ Нэг багшид ногдох үйлдвэр, аж ахуй нэгжийн санхүүжилттэй судалгааны орлого 3.5 сая төгрөгт хүрнэ.
1.3.2. МУИС-ийн харьяа судалгааны хүрээлэн, төвүүдийн орлогын эх үүсвэрийг нэмэгдүүлэх	✓ МУИС-ийн харьяа судалгааны хүрээлэн, төвүүдийн орлого жил тутамд 10 хувиар нэмэгдэнэ.
1.3.3. Улсын төсвөөс авах судалгааны суурь санхүүжилтийг нэмэгдүүлэх	✓ Улсын төсвөөс авах судалгааны суурь санхүүжилт нийт судалгааны төсвийн 20 хувьд хүрнэ.
1.3.4. Багш, суралцагчдын оюуны бүтээлийг эдийн засгийн эргэлтэд оруулж, орлогыг нэмэгдүүлэх	✓ Багш, суралцагчдын оюуны бүтээлээс олох орлого жил тутамд 10 хувиар нэмэгдэнэ.

ГҮЙЦЭТГЭЛИЙН ТҮЛХҮҮР ҮЗҮҮЛЭЛТ

- Судалгаа, инновацын ажлын орлого жилд 20 тэрбум төгрөгт хүрнэ.
- Гадаадын санхүүжилттэй судалгааны орлогыг нэмэгдүүлж 8 тэрбум төгрөгт хүргэнэ.
- Нэг багшид ногдох үйлдвэр, аж ахуйн нэгжийн санхүүжилттэй судалгааны орлого 3.5 сая төгрөгт хүрнэ.
- МУИС-ийн харьяа судалгааны хүрээлэн, сургалт, судалгааны төвүүдийн орлого жил тутамд 10 хувиар нэмэгдэнэ.
- Улсын төсвөөс авах судалгааны суурь санхүүжилт нийт судалгааны төсвийн 20 хувьд хүрнэ.
- Багш, суралцагчдын оюуны бүтээлээс олох орлого жил тутамд 10 хувиар нэмэгдэнэ.

4.2. ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ 2. СУРГАЛТ – Дэлхийд өрсөлдөх чадвартай оюунлаг иргэдийг бэлтгэнэ.

Эдүгээ дэлхий дахинд зайн сургалт, сургалтын уян хатан хэлбэрүүд өргөжиж, хиймэл оюун ухаан, мэдээллийн технологийн ололтод тулгуурлан хувь хүн бүрийн хэрэгцээ шаардлагад нийцсэн сургалт хүрээгээ тэлж байна. Дижитал мэдлэг, нээлттэй боловсролын тогтолцоо дэлгэрч, хүмүүнлэг энэрэнгүй, суралцахуйд суралцсан иргэн улс орон бүрд чухал хэрэгцээт зүйл боллоо. МУИС нь үндэсний, тэргүүлэх их сургуулийн хувьд улс орны хөгжлийн зорилт, хөдөлмөрийн зах зээлийн эрэлт шаардлагад нийцүүлэн сургалтын хөтөлбөрөө шинэчлэх, ахисан түвшний сургалтад төвлөрөх, сургалтад шинэ арга барил нэвтрүүлэх, төгсөгчдөө дэлхийд өрсөлдөхүйц түвшинд бэлтгэх шаардлагатай байна. Иймд дэлхийд өрсөлдөх чадвартай оюунлаг иргэдийг бэлтгэх тэргүүлэх чиглэлийн хүрээнд дараах зорилгыг дэвшүүлэв. Үүнд:

Зорилго 2.1. Сургалтын хөтөлбөрт шинэчлэл хийж, шилдэг хөтөлбөрөөр ялгарна.

Зорилго 2.2. Суралцагчийн хөгжлийг дэмжиж, суралцахуйд суралцсан иргэдийг төлөвшүүлнэ.

Зорилго 2.3. Сургалтын олон талт хэлбэрийг өргөжүүлнэ.

Зорилго 2.1. Сургалтын хөтөлбөрт шинэчлэл хийж, шилдэг хөтөлбөрөөр ялгарна

Хөдөлмөрийн зах зээл, ажил олгогчийн эрэлт шаардлагад нийцсэн өндөр ур чадвартай, шилдэг төгсөгчийг бэлтгэхэд чиглэсэн хөтөлбөрийн шинэчлэл хийнэ.

Хүснэгт 4. Зорилго 2.1-г хэрэгжүүлэх стратеги, хүрэх үр дүн

ХЭРЭГЖҮҮЛЭХ СТРАТЕГИ	ХҮРЭХ ҮР ДҮН
2.1.1. Улсын хөгжлийн бодлого, хөдөлмөрийн зах зээлийн шаардлагад нийцсэн сургалтын шинэ хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх	✓ Зах зээлийн эрэлтэд нийцсэн шинэ хөтөлбөрүүдтэй болсон байна. ✓ Улсдаа тэргүүлэх шилдэг хөтөлбөрөөр ялгарч, элсэгчдийг татна. ✓ Салбар дундын хөтөлбөрүүдийн тоог нэмэгдүүлнэ.



2.1.2. Чансаа өндөртэй гадаадын их сургуулиудтай хамтарсан болон гадаад хэлээрх сургалтын хөтөлбөрүүд боловсруулан хэрэгжүүлэх	✓ Хамтарсан хөтөлбөрийн тоог 10-д хүргэнэ. ✓ Англи хэлээр хэрэгжүүлдэг хөтөлбөрийн тоог 10-д хүргэнэ. ✓ Гадаад харилцааг өргөжүүлж, гадаад суралцагчийн тоог нэмэгдүүлсэн байна.
2.1.3. Суралцагчийн суралцах сонголтыг өргөжүүлэх	✓ Хавсарга хөтөлбөрийн тоог нэмэгдүүлж, хос болон хавсаргаар суралцагчийн тоог нийт суралцагчийн 5 хувьд хүргэнэ. ✓ “Бакалавр + Магистр”, “Магистр + Доктор” нэгдмэл агуулгатай хөтөлбөрөөр суралцах боломжийг өргөжүүлж, суралцагчийн тоог нэмэгдүүлсэн байна.
2.1.4. Сургалтын хөтөлбөрийг чанаржуулах	✓ Дотооддоо хөтөлбөрийн чанарын баталгаажуулалтыг хийдэг болсон байна. ✓ Чанарын баталгаажуулалтын тогтолцоогоор дамжуулан суралцагч, төгсөгчийн чанар сайжирсан байна. ✓ Сургалтын болон хичээлийн хөтөлбөрүүдэд тогтвортой хөгжил, дижитал шилжилтийн агуулгыг тусгасан байна.
2.1.5. Сургалтын хөтөлбөрүүдээ үндэсний болон олон улсын магадлан итгэмжлэлээр итгэмжлүүлэх	✓ Идэвхтэй хэрэгжиж буй хөтөлбөрийн 75 хувийг үндэсний хэмжээнд магадлан итгэмжлүүлсэн байна. ✓ Олон улсад магадлан итгэмжлэгдсэн хөтөлбөрийн тоог 2 дахин нэмэгдүүлсэн байна.
2.1.6. Сургалтын хөтөлбөрүүдийн санхүүгийн үр ашгийг сайжруулах	✓ Сургалтын хөтөлбөрийг олон талт эх үүсвэрээс санхүүжих, үр ашигтай ажиллах нөхцөлийг бүрдүүлсэн байна. ✓ Санхүүгийн алдагдалтай хөтөлбөрүүдийн тоо багасна.

ГҮЙЦЭТГЭЛИЙН ТҮЛХҮҮР ҮЗҮҮЛЭЛТ

- Гадаадын их сургуультай хамтарсан хөтөлбөрийг тоог 10-д хүргэнэ.
- Англи хэлээрх хөтөлбөрийн тоог 10-д хүргэнэ.
- Идэвхтэй хэрэгжиж буй хөтөлбөрийн 75 хувийг үндэсний хэмжээнд магадлан итгэмжлүүлнэ.
- Олон улсад магадлан итгэмжлэгдсэн хөтөлбөрийн тоог 2 дахин нэмэгдүүлнэ.

Зорилго 2.2. Суралцагчийн хөгжлийг дэмжиж, суралцахуйд суралцсан иргэдийг төлөвшүүлнэ

Суралцагчийг хөгжүүлэх, төлөвшүүлэх олон талт үйл ажиллагааны үр дүнд улсын хөгжлийн бодлогыг тодорхойлох, хэрэгжүүлэх чадвар бүхий дараа үеийн оюунлаг манлайлагчдыг бэлтгэхийг үндсэн зорилго болгоно. Суралцагчийн хөгжлийн хөтөлбөрүүдийг тэднийг идэвхжүүлэх, зөөлөн ур чадварт сургах, ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, сэтгэл ханамжтай суралцахад чиглүүлж, МУИС-д суралцагчийг боловсролтой, мэдлэгтэй, олон талт авьяастай, харилцааны соёлтой, өв тэгш хүмүүжилтэй нийгмийн гишүүн болгон бэлтгэнэ.

Хүснэгт 5. Зорилго 2.2-г хэрэгжүүлэх стратеги, хүрэх үр дүн

ХЭРЭГЖҮҮЛЭХ СТРАТЕГИ	ХҮРЭХ ҮР ДҮН
2.2.1. Шинэ элсэгчдэд зориулсан хөтөлбөр хэрэгжүүлж хэвших	✓ Шинэ элсэгчийг суралцахуйд чиглүүлэх, идэвхжүүлэх, МУИС-ийн гишүүн болгон төлөвшүүлэх хөтөлбөр, цуврал арга хэмжээг хэрэгжүүлж хэвшсэн байна.
2.2.2. Суралцагчийн хөгжил, төлөвшлийн олон талт үйл ажиллагааг төлөвлөж, тогтмолжуулах	✓ Суралцагчийн хөгжил, төлөвшлийн цогц хөтөлбөр хэрэгжүүлж, нийт суралцагчийн 40-с дээш хувийг хамруулдаг байна. ✓ Суралцагчийн нийгмийн идэвх оролцоог баталгаажуулдаг болно. ✓ Суралцагчийг үндэсний өв уламжлал, тогтвортой хөгжлийн мэдлэгтэй, хүний эрх, ёс зүй, жендэрийн мэдрэмжтэй, зөөлөн ур чадвартай болгон төлөвшүүлнэ.
2.2.3. Гадаад суралцагчийн зорилтот хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлэх	✓ Гадаад суралцагчийн тоог нийт суралцагчийн 10 хувьд хүргэсэн байна.



2.2.4. Ахисан түвшний суралцагчийн зорилтот хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлэх	✓ Ахисан түвшний суралцагчийн тоог нийт суралцагчийн 35 хувьд хүргэнэ. ✓ Сургалтын орлогод ахисан түвшний сургалтаас оруулах орлогын хэмжээг нэмэгдүүлсэн байна. ✓ Ассистантшип хөтөлбөрийг өргөжүүлж, хамрагдсан суралцагчдын тоог 2 дахин нэмэгдүүлнэ.
2.2.5. Шилдэг суралцагчийг дэмжих, урамшуулах	✓ Шилдэг суралцагчид олгох тэтгэлгийг өргөжүүлж, тэтгэлэг авсан суралцагчийн тоог бакалаврын болон ахисан түвшинд тус бүр 10 хувьд хүргэнэ.
2.2.6. Суралцагчийн бие бялдар, сэтгэл зүй, эрүүл мэндийн үйлчилгээг өргөжүүлэх	✓ Суралцагчийн бие бялдар, эрүүл мэнд, сэтгэл зүйн зөвлөх үйлчилгээний төрөл, хүртээмжийг нэмэгдүүлсэн байна.
2.2.7. Карьер төлөвлөлт, ажлын байранд зуучлах хөтөлбөр хэрэгжүүлэх	✓ МУИС-д цагийн хөдөлмөр эрхлэх суралцагчийн тоог 400-д хүргэнэ. ✓ МУИС-ийн зуучлах үйлчилгээгээр ажилтай болсон суралцагчийн тоог 1200-д хүргэнэ. ✓ Төгсөгчдийн ажил эрхлэлтийг 80 хувьд хүргэнэ.
2.2.8. Оюутан солилцоог өргөжүүлэх	✓ Гадаадын сургуульд оюутан солилцоогоор суралцагчийн тоог нийт оюутны 2 хувьд хүргэнэ.
2.2.9. Суралцагчийн сэтгэл ханамжийн судалгааг тогтмолжуулж, үр дүнд үндэслэн үйл ажиллагааг сайжруулдаг байх	✓ Сэтгэл ханамжийн үнэлгээг 92 хувьд хүргэнэ. ✓ Судалгааны үр дүнд үндэслэн сургалт, оюутны хөгжлийн хөтөлбөрүүдээ сайжруулдаг болно.

ГҮЙЦЭТГЭЛИЙН ТҮЛХҮҮР ҮЗҮҮЛЭЛТ

- Гадаад суралцагчийн тоог нийт суралцагчийн 10 хувьд хүргэнэ.
- Ахисан түвшний суралцагчийн тоог нийт суралцагчийн 35 хувьд хүргэнэ.
- Ассистантшип хөтөлбөрт хамрагдсан суралцагчийн тоог 2 дахин нэмэгдүүлнэ.
- МУИС-д цагийн хөдөлмөр эрхлэх оюутны тоог 400-д хүргэнэ.
- Төгсөгчийн ажил эрхлэлтийг 80 хувьд хүргэнэ.
- Гадаадын сургуульд оюутан солилцоогоор суралцагчийн тоог нийт оюутны 2 хувьд хүргэнэ.
- Суралцагчийн сэтгэл ханамжийн дундаж үнэлгээг 92 хувьд хүргэнэ.

Зорилго 2.3. Сургалтын олон талт хэлбэрийг өргөжүүлнэ

Орчин үеийн суралцагчийн онцлог, хэрэгцээ шаардлагад нийцсэн олон талт сургалтын хэлбэрийг нэвтрүүлэхийн зэрэгцээ орон зайнаас үл хамааран мэдлэг чадвараа дээшлүүлэх, мэргэжил эзэмших боломжийг суралцагчдад олгох, мөн нийтэд зориулсан нээлттэй цахим сургалтыг нэмэгдүүлж, насан туршийн боловсролд хувь нэмэр оруулна.

Хүснэгт 6. Зорилго 2.3-г хэрэгжүүлэх стратеги, хүрэх үр дүн

ХЭРЭГЖҮҮЛЭХ СТРАТЕГИ	ХҮРЭХ ҮР ДҮН
2.3.1. Цахим сургалтын хүртээмжийг нэмэгдүүлэх	✓ Цахим сургалтын журмыг шинэчилнэ. ✓ Иж бүрэн цахим хөтөлбөрийг 5-д хүргэж, хүртээмжийг нэмэгдүүлсэн байна. ✓ Цахим сургалтыг ашиглан салбар сургуулиудын сургалтын зардлыг бууруулна.
2.3.2. Насан туршийн суралцахуйг дэмжсэн сургалтын тоо, хүртээмжийг нэмэгдүүлэх	✓ Зэргийн бус сургалтын журам боловсруулж хэрэгжүүлнэ. ✓ Зэргийн бус сургалтын төрөл, оролцогчийн тоог нэмэгдүүлж, сургалтын орлогод эзлэх хэмжээг 2 хувьд хүргэнэ. ✓ Насан туршийн суралцахуйд хувь нэмэр оруулж, нийгэмд эзлэх байр суурь, нэр хүнд дээшилнэ.
2.3.3. Англи хэлээр заах хичээлийн тоог нэмэгдүүлэх	✓ Англи хэлээр заах хичээлийн тоог 100-д хүргэнэ.



2.3.4. Сургалтыг шинэлэг, уян хатан, олон хэлбэрээр зохион байгуулах	✓ Сургалтыг уян хатан, олон хэлбэр (танхим, цахим, хосолсон, блок гэх мэт)-ээр үр ашигтай зохион байгуулна. ✓ Хичээлээр суралцагчид олгох мэдлэг ур чадварт үндэслэн ерөнхий суурийн багцад шинэчлэл хийсэн байна.
2.3.5. Сургалтад орчин үеийн технологи, арга зүйг нэвтрүүлэх	✓ Сургалтын арга зүй, технологи, хэрэглэгдэхүүнийг орчин үеийн чиг хандлагад нийцүүлэн сайжруулсан байна.

ГҮЙЦЭТГЭЛИЙН ТҮЛХҮҮР ҮЗҮҮЛЭЛТ

- Иж бүрэн цахим хөтөлбөрийн тоог 5-д хүргэнэ.
- Зэргийн бус сургалтын орлогын нийт сургалтын орлогод эзлэх хувийг 2 хувьд хүргэнэ.
- Англи хэлээр заах хичээлийн тоог 100-д хүргэнэ.

4.3. ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ 3. НИЙГМИЙН ОРОЛЦОО – Хамтын ажиллагаагаар нийгэмд тогтвортой үнэ цэнийг бүтээнэ.

Бид шинжлэх ухааны хөгжлийн үндэсний түүчээлэгчийн хувьд сургалт, эрдэм шинжилгээгээр манлайлж, нийгмийг хөгжүүлэгч хүч болсон тэргүүлэх их сургууль байна. МУИС нь оролцогч талуудтай үр дүнтэй хамтран ажиллаж, нийгэмд тогтвортой үнэ цэнийг бүтээнэ хэмээх тэргүүлэх чиглэлийн хүрээнд дараах зорилгыг дэвшүүллээ. Үүнд:

Зорилго 3.1. Нийгмийг хөгжүүлэгч тэргүүлэх судалгааны байгууллага байна.

Зорилго 3.2. Нийгэмд эерэг өөрчлөлтийг бий болгоход нөлөөлөх шинжлэх ухаанч, соён гэгээрүүлэгч, академик байгууллага байна.

Зорилго 3.3. Тогтвортой хөгжлийг дэмжсэн, байгаль орчинд ээлтэй үйл ажиллагааны орчныг бүрдүүлнэ.

Зорилго 3.1. Нийгмийг хөгжүүлэгч тэргүүлэх судалгааны байгууллага байна

Нийгмийг хөгжүүлэгч тэргүүлэх судалгааны байгууллага, хараат бус мэргэжлийн институтийн хувьд УИХ-д өргөн мэдүүлсэн хууль, тогтоомжийн

төсөл Монгол Улсын урт, дунд хугацааны хөгжлийн бодлого, салбарын стратегийн баримт бичгүүдийг боловсруулах үйл явцад тогтмол оролцож, профессор багшийн санал, дүгнэлт, зөвлөмжүүдийг тусгадаг болно. Мөн МУИС нь монгол хэл бичиг, соёл уламжлалаа дээдлэх, түгээх болон үндэсний дархлааг бэхжүүлэхэд үнэт хувь нэмэр оруулна.

Хүснэгт 7. Зорилго 3.1-г хэрэгжүүлэх стратеги, хүрэх үр дүн

ХЭРЭГЖҮҮЛЭХ СТРАТЕГИ	ХҮРЭХ ҮР ДҮН
3.1.1. Төрийн бодлого боловсруулах, шийдвэр гаргахад профессор багшийн оролцоог нэмэгдүүлэх	✓ Боловсруулсан, үнэлэлт дүгнэлт өгч оролцсон хууль тогтоомж, төрийн бодлогын баримт бичгийн тоог 15 хувиар нэмэгдүүлнэ.
3.1.2. Бүс нутгийн хөгжлийг дэмжих судалгааны төв байгуулах	✓ Салбар сургуулиа түшиглэн бүсийн хөгжлийг дэмжих судалгааны төвийг байгуулж, үйл ажиллагааг эхлүүлсэн байна.
3.1.3. Салбарын болон аж үйлдвэрийн суурь болон хэрэглээний судалгааг хийж гүйцэтгэх	✓ Монгол Улсад тулгамдаж буй асуудлаар салбарын судалгааг гүйцэтгэсэн байна. ✓ Салбарын болон аж үйлдвэрийн захиалгат төсөлт ажлын тоог 20 хувиар нэмэгдүүлнэ.
3.1.4. Монгол хэл бичиг, соёл уламжлал, үндэсний дархлааг дэмжихэд чиглэсэн тусгай хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлэх	✓ Монгол хэл бичиг, соёл уламжлал, үндэсний дархлааг дэмжих хөтөлбөрийг хэрэгжүүлсэн байна. ✓ Гадаад улсад суугаа монгол иргэдэд хэл, соёл, түүх, уламжлалыг түгээн өвлүүлэх хөтөлбөрийг хэрэгжүүлсэн байна. ✓ Гадаадын иргэдэд зориулсан Монгол хэлний хөтөлбөрийг хэрэгжүүлсэн байна. ✓ Монголын соёл, түүхийг сурталчлан таниулах цахим хичээл, контентуудыг англи хэлээр бэлтгэн хүргэсэн байна.



3.1.6. Мэргэжлийн холбоод болон бизнесийн байгууллагуудтай хамтарсан судалгааг хийж гүйцэтгэх	✓ Мэргэжлийн холбоодтой хамтарсан судалгааны тоог 50-д хүргэсэн байна. ✓ Бизнесийн байгууллагуудтай тогтвортой хамтын ажиллагааг бий болгосон байна.
---	--

ГҮЙЦЭТГЭЛИЙН ТҮЛХҮҮР ҮЗҮҮЛЭЛТ

- Боловсруулсан, үнэлэлт дүгнэлт өгч оролцсон хууль тогтоомж, төрийн бодлогын баримт бичгийн тоог 15 хувиар нэмэгдүүлнэ.
- Салбарын болон аж үйлдвэрийн захиалгат төсөлт ажлын тоог 20 хувиар нэмэгдүүлнэ.
- Мэргэжлийн холбоодтой хамтарсан төсөл, хөтөлбөрийн тоо 50-д хүрсэн байна.

Зорилго 3.2. Нийгэмд эерэг өөрчлөлтийг бий болгоход нөлөөлөх шинжлэх ухаанч, соён гэгээрүүлэгч, академик байгууллага байна

МУИС нь бүх нийтийн боловсрол, нээлттэй боловсролыг бий болгоход өөрсдийн хувь нэмрээ оруулах замаар иргэдийн соёл, боловсролын түвшнийг дээшлүүлэх, бүх нийтийн боловсрол, үндэсний соёлын дархлааг бэхжүүлэх ажлыг санаачлан гүйцэтгэж нийгмийн өмнө хүлээсэн үүргээ биелүүлнэ. Олон нийтийн мэдээллийн хэрэгсэл болон оролцогч талын түлхүү ашигладаг дижитал сувгуудаар тэдэнд зориулсан контент, нэвтрүүлгүүдийг бий болгож нийгэмд эерэг, шинжлэх ухаанч, хүчирхэг нөлөөлөл бий болгоно.

МУИС-ийн сургалт, эрдэм шинжилгээ, нийгэмд чиглэсэн үйл ажиллагаанууд, тэдгээрийн үр дүн, амжилт, сургуулийн орчинд өрнөж буй арга хэмжээнүүдийн талаар олон нийтэд мэдээлж, үр дүнг хуваалцахад онцгой анхаарна. Ялангуяа оролцогч талуудтай үр дүнтэй хамтран ажиллах замаар нийгэмд нөлөө үзүүлэхүйц бодит ажлуудыг гүйцэтгэх болно.

Хүснэгт 8. Зорилго 3.2-г хэрэгжүүлэх стратеги, хүрэх үр дүн

ХЭРЭГЖҮҮЛЭХ СТРАТЕГИ	ХҮРЭХ ҮР ДҮН
3.2.1. Бүх нийтийн шинжлэх ухаанч хандлага, нээлттэй боловсролд чиглэсэн хөтөлбөр хэрэгжүүлэх	✓ Мэдээллийн хэрэгсэл, дижитал сувгаар шинжлэх ухаанч, эерэг нөлөөлөл бүхий контент нэвтрүүлгийг бүтээн, олон нийтэд хүргэсэн байна. ✓ Профессор багшийн судалгааны ажлын үр дүнг сурталчлах контентын тоог нэмэгдүүлнэ. ✓ Улс оронд тулгамдсан асуудалд профессор багш нар шинжлэх ухааны үндэслэлтэй тайлбар, зөвлөмжийг олон нийтэд хүргэсэн байна.
3.2.2. МУИС-д өрнөж буй онцлох үйл ажиллагааг оролцогч талууд болон олон нийтэд тогтмол мэдээлж, сурталчлах	✓ МУИС-ийн сургалт, эрдэм шинжилгээ, нийгэмд чиглэсэн онцлох үйл ажиллагааны талаарх мэдээллийг зорилтот бүлгүүдэд түгээнэ. ✓ Хандалтын тоог өсгөж, контентуудыг чанаржуулна.
3.2.3. Оролцогч талуудтай хамтран нийгэмд чиглэсэн үйл ажиллагааг эрчимжүүлэх	✓ Оюутны холбоо, клубтэй хамтран нийгэмд чиглэсэн хөтөлбөр, үйл ажиллагааг хэрэгжүүлсэн байна. ✓ МУИС-ийн гадаад оюутны холбоо байгуулагдаж, үйл ажиллагаа нь идэвхэжсэн байна. ✓ Төгсөгчдийн холбооны үйл ажиллагаа идэвхэжсэн байна. ✓ Ажил олгогч, төрийн болон бизнесийн байгууллага, холбоод, гадаадын болон олон улсын байгууллага зэрэг оролцогч талуудтай нийгэмд чиглэсэн үйл ажиллагаа хэрэгжүүлсэн байна.
3.2.4. Суралцагч, профессор багш, ажилтны нийгэмд чиглэсэн үйл ажиллагааг дэмжих	✓ Суралцагч, профессор багш, ажилтны нийгэмд чиглэсэн үйл ажиллагаа идэвхэжсэн байна.

**ГҮЙЦЭТГЭЛИЙН ТҮЛХҮҮР ҮЗҮҮЛЭЛТ**

- Мэдээллийн хэрэгсэл, дижитал сувгаар нийгэмд хүргэсэн контент нэвтрүүлгийн тоо 50-д хүрсэн байна.
- Оюутны холбоо, клубтэй хамтран нийгэмд чиглэсэн 10 төсөлт үйл ажиллагааг жил тутамд хэрэгжүүлсэн байна.
- МУИС-ийн гадаад оюутны холбоо байгуулагдаж, үйл ажиллагаа нь тогтмолжсон байна.
- Төгсөгчдийн холбоо, ажил олгогч, төрийн болон бизнесийн байгууллага, холбоод, гадаадын болон олон улсын байгууллага зэрэг оролцогч талуудтай нийгэмд чиглэсэн 120 төсөлт үйл ажиллагааг хэрэгжүүлсэн байна.

Зорилго 3.3. Тогтвортой хөгжлийг дэмжсэн, байгаль орчинд ээлтэй үйл ажиллагааны орчныг бүрдүүлнэ

Хүрээлэн буй орчин, экологийн чиглэлээр сургалт, судалгаа явуулдаг байгууллагын хувьд МУИС нь байгаль орчны асуудалд нухацтай хандаж, өөрийн үйл ажиллагаанаас үүдэж болзошгүй байгаль орчны сөрөг нөлөөллийг бууруулахад тууштай ахиц гаргаж, тогтвортой хөгжил, инновацыг хөгжүүлэх боломжийг эрэлхийлэх шаардлагатай. Дэлхий нийтийн нэгдмэл зорилт болсон Тогтвортой хөгжлийн үзэл баримтлалыг түгээн дэлгэрүүлэх, холбогдох зорилтуудыг хэрэгжүүлэхэд МУИС манлайлан ажиллахыг зорино.

2025-2030 оны стратеги төлөвлөгөөний хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй багш, ажилтан, суралцагчийн тэгш сурч, хөдөлмөрлөх таатай орчныг бүрдүүлэхэд онцгой анхаарч холбогдох хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэн ажиллах болно. Ингэснээр хүнээ дээдэлсэн хүмүүнлэг, ээлтэй орчин бүрдэх юм. Мөн байгаль орчин, нийгэм, засаглал (БОНЗ)-ын тайлагналыг бий болгож, үр дүнг хэлэлцүүлдэг болсноор их сургууль нийгмийн өмнө хүлээх хариуцлагаа биелүүлж, үйл ажиллагааг ирээдүйд илүү төгөлдөржүүлэх боломжтой юм.

Хүснэгт 9. Зорилго 3.3-г хэрэгжүүлэх стратеги, хүрэх үр дүн

ХЭРЭГЖҮҮЛЭХ СТРАТЕГИ	ХҮРЭХ ҮР ДҮН
3.3.1. Нэмэлт хэрэгцээтэй (хөгжлийн бэрхшээлтэй, цөөнхийн бүлэг болон бусад) иргэдэд ээлтэй сурч, ажиллах орчныг бий болгох зорилтот хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлэх	✓ Нэмэлт хэрэгцээтэй (хөгжлийн бэрхшээлтэй, цөөнхийн бүлэг болон бусад) иргэдэд ээлтэй, тэгш хамрагдан сурах, хөдөлмөрлөх орчин бүрдсэн байна.



3.3.2. Ногоон хөгжил, байгаль орчинд ээлтэй үйл ажиллагааг нэвтрүүлэх	✓ Сургуулийн эзэмшлийн нийт талбайд ногоон байгууламж бүхий талбайг 20 хувиар нэмэгдүүлнэ. ✓ Ахуйн хог хаягдлыг 80 хувь ангилан ялгаж, дараагийн боловсруулах шатанд хүлээлгэн өгдөг болно. ✓ Захиргаа, сургалтын үйл ажиллагаанд цахим технологийг нэвтрүүлж, цаасны хэрэглээг 50 хувь бууруулсан байна. ✓ Сэргээгдэх эрчим хүчний хэрэглээг нийт эрчим хүчний хэрэглээний 5-аас доошгүй хувьд хүргэсэн байна. ✓ Эрчим хүчний ашиглалтын зардлыг бууруулсан байна. ✓ Усны хэмнэлтийг бий болгож саарал усны хэрэглээг нэвтрүүлсэн байна.
3.3.3. Тогтвортой хөгжил, нийгмийн хариуцлагын хүрээнд гадаад дотоодын мэргэжлийн холбоод, байгууллагуудтай хамтарсан төсөл, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх	✓ Чанартай боловсролыг дэмжих, жендэрийн эрх тэгш байдлыг хангах, хөгжлийн төлөөх түншлэлийг бэхжүүлэх Тогтвортой хөгжлийн зорилтуудыг биелүүлэхэд хувь нэмрээ оруулсан байна. ✓ Тогтвортой хөгжлийн үзэл баримтлалыг хөгжүүлэхэд чиглэсэн сургалт, семинар, хөтөлбөрүүд нэмэгдсэн байна. ✓ Тогтвортой хөгжлийн үзэл баримтлалыг нутагшуулах, хэрэгжүүлэхэд чиглэсэн зөвлөмж, удирдамж боловсруулж, түгээн дэлгэрүүлсэн байна.

**ГҮЙЦЭТГЭЛИЙН ТҮЛХҮҮР ҮЗҮҮЛЭЛТ**

- Хөгжлийн бэрхшээлтэй багш, ажилтан, суралцагчдыг дэмжсэн зорилтот хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн үйл ажиллагааны тоог 25-д хүргэнэ.
- Сургуулийн эзэмшлийн талбайд эзлэх ногоон байгууламжийг 20 хувиар нэмэгдүүлнэ.
- Ахуйн хог хаягдлыг 80 хувь ангилан ялган, дараагийн боловсруулах шатанд хүлээлгэн өгдөг болно.
- Захиргаа, сургалтын үйл ажиллагаанд цахим технологийг нэвтрүүлж, цаасны хэрэглээг 50 хувь бууруулсан байна.
- Байгаль орчин, нийгэм, засаглал (БОНЗ)-ын тайлан жил бүр гаргана.

4.4. ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ 4. НӨӨЦ – Байгууллагын нөөцийн оновчтой удирдлагыг хөгжүүлнэ.

Аливаа их сургуулийн нэр хүнд нь багш, профессорын ур чадвар болон төгсөгчдийн мэдлэг, бүтээж туурвисан бүтээлийн чанар чансаа, нийгэмд хүргэж буй үнэ цэн зэргээр тодорхойлогддог. Сайн их сургууль байхын тулд оюуны өндөр чадамжтай профессор багш, ажилтнуудаас бүрдсэн хамт олныг бүрдүүлэх нь чухал. МУИС-ийн гол нөөц болох профессор багш, ажилтны бүрэлдэхүүнийг чанаржуулах, авьяастны төвлөрлийг бий болгох, нөөцийн удирдлагын бодлогын хүрээнд дор дурдсан 3 үндсэн арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

- Багш судлаачдыг ажилд сонгон шалгаруулж авах, ажлын гүйцэтгэлийг үнэлэх, үр дүнд тулгуурлан урамшуулах тогтолцоог бүрдүүлэх
- Багш судлаачдын ажиллах тааламжтай орчин нөхцөлийг бүрдүүлэх
- Гадаад хамтын болон олон талт орлогын эхүүсвэр, хөрөнгө оруулалтын оновчтой удирдлагаар байгууллагаа чадавхжуулах.

Стратеги төлөвлөгөөний хүрээнд байгууллагын нөөцийн оновчтой удирдлагыг хөгжүүлэх тэргүүлэх чиглэлийн хүрээнд дараах зорилгуудыг дэвшүүллээ. Үүнд:

Зорилго 4.1. Хүний нөөцийн бодлогоор авьяастны төвлөрлийг бий болгоно.

Зорилго 4.2. Сурах, ажиллах, хөгжих таатай орчныг бүрдүүлнэ.

Зорилго 4.3. Орлогын олон талт эх үүсвэрийг бүрдүүлж, үр ашигт чиглэсэн хөрөнгө оруулалтын тогтолцоог бий болгоно.



Зорилго 4.1. Хүний нөөцийн бодлогоор авьяастны төвлөрлийг бий болгоно

Хүний нөөцийн бодлогоор авьяастны төвлөрлийг бий болгохын тулд чадварлаг хүний нөөцийг татах тогтолцоог сайжруулж, дотоод болон гадаад профессор багш, ажилтныг ажилд сонгон шалгаруулж авах, ажлыг бодитойгоор үнэн зөв үнэлэх, үнэлгээндээ тулгуурлан урамшуулах, зэрэглэл ахиулах мерит зарчмыг хэрэгжүүлнэ. Чадварлаг хүний нөөцөө тасралтгүй хөгжүүлэх, хамтарсан төсөл, солилцооны хөтөлбөр хэрэгжүүлэх, нийгмийн асуудлуудад нь анхаарч тогтвортой ажиллуулах нөхцөлийг сайжруулна.

Хүснэгт 10. Зорилго 4.1-г хэрэгжүүлэх стратеги, хүрэх үр дүн

ХЭРЭГЖҮҮЛЭХ СТРАТЕГИ	ХҮРЭХ ҮР ДҮН
4.1.1. Чадварлаг хүний нөөцийг татах	✓ Чадварлаг, мэргэшсэн дотоод болон гадаад профессор багш, ажилтныг татах тогтолцоог сайжруулна. Гадаадын профессор багш болон гадаадын нэр хүндтэй их сургуульд ажиллаж буй монгол багш, судлаачийг МУИС-д давхар харьяалалтай ажиллах бололцоог бүрдүүлж гадаадын профессор багш болон гадаадаас хичээл заах монгол багш, судлаачийн нийт багшид эзлэх хувийг 10 хувьд хүргэнэ.
4.1.2. Ажлын ачаалал, гүйцэтгэл, үр дүнд суурилсан цалин хөлс, урамшууллын тогтолцоог сайжруулах	✓ МУИС-ийн профессор багш, ажилтны дундаж цалинг 2 дахин нэмэгдүүлсэн байна. ✓ Багш, ажилтны хөгжлийг дэмжих үйл ажиллагааны санхүүжилтийг бакалаврын сургалтын орлогын 2.5 хувьд хүргэнэ. ✓ Жилийн ажлын үр дүнгийн урамшууллыг олгох процессыг шинэчилнэ. ✓ МУИС-ийн орлого нэмэгдүүлсэн профессор багш, ажилтныг урамшуулах тогтолцоо сайжирна. ✓ Төрөөс баримталж буй бүсчилсэн хөгжлийн бодлогын хүрээнд орон нутгийн салбар сургуулийн профессор багш, ажилтны цалин, урамшуулалд дэмжлэг авна.



4.1.3. Хүний нөөцийг тасралтгүй хөгжүүлэх	✓ Хүний нөөцийг хөгжүүлэх цогц хөтөлбөр хэрэгжүүлнэ. ✓ Багшийн сургалт, судалгаа, инновацын чадамж сайжирсан байна. ✓ Гадаад, дотоод хамтын ажиллагааны хүрээнд профессор багш, ажилтны мэдлэг, ур чадварыг сайжруулна.
4.1.4. Профессор багш, ажилтны нийгмийн үйлчилгээг сайжруулах	✓ Профессор багш, ажилтны биеийн болон сэтгэл зүйн эрүүл мэндийг дэмжих хөтөлбөрийг хэрэгжүүлнэ. ✓ Арилжааны банкнуудтай хамтран орон сууцны хөнгөлөлттэй зээлийн нөхцөлийг сайжруулсан байна.

ГҮЙЦЭТГЭЛИЙН ТҮЛХҮҮР ҮЗҮҮЛЭЛТ

- Профессор багш, ажилтны дундаж цалинг 2 дахин нэмэгдүүлсэн байна.
- Багш, ажилтны хөгжлийг дэмжих үйл ажиллагааны санхүүжилтийг бакалаврын сургалтын орлогын 2.5 хувьд хүргэнэ.
- Гадаадын профессор багш болон гадаадаас хичээл заах монгол багш, судлаачийн нийт багшид эзлэх хувийг 10 хувьд хүргэнэ.
- Хүний нөөцийг хөгжүүлэх цогц хөтөлбөр хэрэгжсэн байдал.

Зорилго 4.2. Сурах, ажиллах, хөгжих таатай орчныг бүрдүүлнэ

Профессор багш, ажилтан, суралцагчдын сурах, ажиллах, хөгжих таатай орчныг бүрдүүлэхийн тулд хичээлийн байруудыг үе шаттайгаар шинэчлэх, тааламжтай нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээг хэрэгжүүлнэ. Номын сангийн чанар хүртээмжийг сайжруулах, цахим технологид тулгуурлан сургалт, судалгааны үйл ажиллагааг хялбаршуулах, удирдлагын мэдээллийн системийн интеграцийг нэмэгдүүлэн бодит болон виртуал ертөнцийг нэгтгэсэн хосолмол загвараар тогтвортой хөгжлийг цогцлооно.

Хүснэгт 11. Зорилго 4.2-д хүрэх үндсэн үйл ажиллагаа, үр дүн

ХЭРЭГЖҮҮЛЭХ СТРАТЕГИ	ХҮРЭХ ҮР ДҮН
4.2.1. Хичээлийн байруудыг үе шаттайгаар шинэчлэх	✓ Хичээлийн 3, 6-р байрууд ашиглалтад орсон байна. ✓ МУИС-ийн спорт цогцолборыг барьж ашиглалтад оруулна. ✓ Хичээлийн 4-р байрны шинэ барилгын ажлыг эхлүүлсэн байна.
4.2.2. Сурах, ажиллах, хөгжих орчин үеийн, шинэлэг таатай орчныг бүрдүүлэх	✓ Сургуулийн анги танхим, өрөө тасалгаа болон үйлчилгээний газрын орчин нөхцөлийг жендэрийн эрх тэгш байдалд нийцүүлж, стандартын дагуу сайжруулна. ✓ Суралцагчдын бие даан суралцах таатай орчин нөхцөлийг сургуулийн сул зай талбайг ашиглаж бүрдүүлсэн байна. ✓ Багш, ажилтны сургуулийн өмнөх насны хүүхдэд чиглэсэн хөтөлбөр хэрэгжүүлсэн байна. ✓ Хичээлийн байр бүрд багш, ажилтанд зориулсан амралтын хэсгийг бий болгосон байна. ✓ Дотуур байр, эмнэлэг, дадлагын бааз, лабораториудыг орчин үеийн шаардлагад нийцүүлж, хүртээмжийг нэмэгдүүлнэ. ✓ Сургалт, судалгааны орчны талаарх багш, ажилтан, суралцагчдын сэтгэл ханамж сайжирсан байна.
4.2.3. Номын сангийн фонд бүрдүүлэлтийн чанар, хүртээмжийг сайжруулах	✓ Номын сангийн фондод мэргэжлийн сурах бичиг, гарын авлагыг нэмэгдүүлж, хүртээмжийг сайжруулна. ✓ Дижитал номын сангийн үйл ажиллагаа өргөжиж, орлого нэмэгдэнэ.



4.2.4. Мэдээллийн технологийн ололт, амжилтыг түүчээлэн хэрэгжүүлэгч, хиймэл оюун ухаан, их өгөгдлийг сургалт, судалгаа, үйл ажиллагаанд ашиглах	✓ Их сургуулийн бодит болон виртуал ертөнцийг нэгтгэсэн хосолмол загвараар тогтвортой үйлчилгээ-сургалт, судалгаа, технологи дамжуулалт үзүүлдэг болно. ✓ Цахим технологид тулгуурлан сургалт, судалгааны үйл ажиллагааг сайжруулан хялбаршуулж, мэдээллийн тэгш хүртээмж нэмэгдэнэ.
4.2.5. Байгууллагын удирдлагын нэгдсэн мэдээллийн системийн хэрэглээ, интеграцийг нэмэгдүүлж, их өгөгдлийн санг бүрдүүлэх	✓ Сургалт, судалгаа, мэдээллийн солилцоо сайжирч, хамтран ажиллах орон зай нэмэгдэнэ. ✓ МУИС-ийн удирдлагын үйл ажиллагаанд технологийн хэрэглээ нэмэгдэнэ. ✓ Эрх зүйн хүрээнд зөвшөөрөгдсөн баримт, мэдээллийг англи, монгол хэлээр цахим архивын хэлбэрт шилжүүлж нийтэлсэн байна. ✓ Байгууллагын удирдлагын нэгдсэн мэдээллийн системийн хэрэглээг бүрэн төлөвшүүлнэ. ✓ Багш, ажилтны мэдээллийн цахим архив, сан бүрдсэн байна.
4.2.6. Мэдээллийн аюулгүй байдлын чиглэлийн хууль, журмыг хэрэгжүүлэх	✓ Мэдээллийн аюулгүй байдал сайжирсан байна.

ГҮЙЦЭТГЭЛИЙН ТҮЛХҮҮР ҮЗҮҮЛЭЛТ

- Шинэчлэгдэн, шинээр ашиглалтад орсон хичээлийн болон бусад барилга, байруудын тоог 3-аас доошгүй болгоно.
- Багш, ажилтанд зориулсан амралтын хэсгийг хичээлийн байр бүрд бий болгоно.
- Номын сангийн фондод мэргэжлийн сурах бичиг, гарын авлагыг 15 хувь нэмэгдүүлнэ.
- Цахим ном, сурах бичгийн тоог 2000-д хүргэнэ.
- Цахим бүтээгдэхүүн, үйлчилгээний тоо 40 хувиар нэмэгдсэн байна.

Зорилго 4.3. Орлогын олон талт эх үүсвэрийг бүрдүүлж, үр ашигт чиглэсэн хөрөнгө оруулалтын тогтолцоог бий болгоно

МУИС-ийн санхүүжилт нь сургалтын орлогод голлон суурилсан бүтэцтэй байгаа нь их сургуулийн үйл ажиллагааг өргөжүүлэх, хөгжүүлэхэд ихээхэн бэрхшээл учруулж байна. Иймээс шилдэг их, дээд сургуулиудын туршлагаас суралцаж, олон талт орлогын эх үүсвэрийг бүрдүүлэх, үр ашигт чиглэсэн хөрөнгө оруулалтад оролцогч талуудаа татан оролцуулах замаар хамтын үнэ цэнийг нийгэмд бүтээхэд хамтран ажиллана. Өндөр үзүүлэлт бүхий лабораторийн үйлчилгээ үзүүлэх, оюуны бүтээлээ эргэлтэд оруулах, байгаа боломжоо нээлттэй байдлаар ашиглаж, төр, хувийн хэвшил, гадаад дотоодын хамтрагчидтай илүү нягт хамтран ажиллаж үр ашгийг нэмэгдүүлнэ.

Хүснэгт 12. Зорилго 4.3-г хэрэгжүүлэх стратеги, хүрэх үр дүн

ХЭРЭГЖҮҮЛЭХ СТРАТЕГИ	ХҮРЭХ ҮР ДҮН
4.3.1. Судалгааны их сургуулийн хувьд төрөөс үзүүлэх дэмжлэг, тусламжийг нэмэгдүүлэх	✓ Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Засгийн газрын мөрийн хөтөлбөрт тусгагдсан аливаа дэмжлэгт хамрагдана. ✓ Шинжлэх ухааны тодорхой чиглэлийн хөгжлийг дэмжсэн улсын төсвийн бодит санхүүжилт бий болно.
4.3.2. Орлогын олон талт эх үүсвэрийг нэмэгдүүлэх	✓ Гадаад, дотоодын их, дээд сургуулиуд, эрдэм шинжилгээ, аж үйлдвэрийн хамтарсан судалгаа шинжилгээ, инновацын төсөл, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж орлого нэмэгдүүлнэ. ✓ Төрийн болон бусад байгууллагын үр ашигтай хамтын ажиллагааг тогтмолжуулж, тогтвортой орлогын эх үүсвэрийг нэмэгдүүлнэ. ✓ Оюуны бүтээлийг эдийн засгийн эргэлтэд оруулах тогтолцоог бүрдүүлнэ. ✓ Судалгааны лабораторийг орчин үеийн жишигт нийцүүлэн магадлан итгэмжлүүлж, захиалгат судалгаа, шинжилгээнээс олох орлогыг нэмэгдүүлнэ. ✓ Бүрэлдэхүүн, салбар сургууль, хүрээлэн, төвүүдийн үйл ажиллагаа, хөрөнгийн ашиглалтыг сайжруулах замаар орлого нэмэгдүүлнэ. ✓ Зах зээлийн эрэлтэд нийцүүлэн зэргийн бус сургалтын олон төрөл хэлбэрийг хөгжүүлэх, брэнд бүтээгдэхүүн, хэвлэлээс олох орлого нэмэгдэнэ.



4.3.3. Төсвийн үр ашигтай хөрөнгө оруулалтын тогтолцоог сайжруулж, тогтвортой санхүүгийн бодлогыг хэрэгжүүлэх	✓ Үр ашигтай төсөв санхүү, хөрөнгө оруулалтын тогтолцоо, механизм бий болсон байна. ✓ Ашигтай ажиллаж буй сургууль, нэгжүүдээ тусгайлсан бодлогоор дэмжин ажиллаж, үр өгөөжийг сайжруулна. ✓ Санхүүгийн эрсдэлийн удирдлага сайжирч тогтвортой байдал бий болно.
4.3.4. Эндаумент сангийн үйл ажиллагааг өргөжүүлж, орлогыг нэмэгдүүлэх	✓ Хөрөнгийн эх үүсвэрийг бүрдүүлэх зорилгоор гадаад, дотоодын их дээд сургуулиуд, эрдэм шинжилгээний байгууллагууд, аж ахуйн нэгж, хөрөнгө оруулалтын сангуудтай хамтран ажилласан байна. ✓ Төгсөгчдийн сургуулийн хөгжилд оруулах хувь нэмэр, хандив тусламжийн орлого нэмэгдсэн байна. ✓ Эндаумент сангийн үр ашигтай багц бүрдэнэ.

ГҮЙЦЭТГЭЛИЙН ТҮЛХҮҮР ҮЗҮҮЛЭЛТ

- Сургалтын бус орлогыг нийт орлогын 40 хувьд хүргэнэ.
- Эндаумент сангийн хэмжээг 60 хувиар өсгөнө.

4.5. ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ 5. ЗАСАГЛАЛ – Сайн засаглалыг төлөвшүүлж, менежментийн чадамжийг бэхжүүлнэ.

МУИС-ийн хөгжлийн бодлогыг тодорхойлох, хэрэгжүүлэх, үнэлж дүгнэх, хэрэгжилтэд нь хяналт тавих үйл явцын үр дүнг нэмэгдүүлэхийн тулд их сургуулийн засаглалыг бэхжүүлэх, байгууллагын үйл ажиллагааг олон улсын шаардлагад нийцүүлэх шаардлагатай юм. Сайн засаглалыг төлөвшүүлж, менежментийн чадамжийг бэхжүүлэх тэргүүлэх чиглэлийн хүрээнд дараах зорилгыг дэвшүүлэв. Үүнд:

Зорилго 5.1. Удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагааг олон улсын сайн засаглалын туршлагад нийцүүлнэ.

Зорилго 5.2. Цахим засаглалыг хөгжүүлж, байгууллагын менежментийн чадамжийг бэхжүүлнэ.

Зорилго 5.3. Стратегийн хэрэгжүүлэлтийн үйл явцыг боловсронгуй болгоно.

Зорилго 5.1. Удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагааг олон улсын сайн засаглалын туршлагад нийцүүлнэ

МУИС-ийн засаглалыг чиглүүлэх, хэрэгжүүлэх, хяналт тавих тогтолцоо гэж авч үзсэн болно. Байгууллагыг “чиглүүлэх” гэдэгт стратегийг томъёолох, батлах үйл явцыг хамруулан Удирдах зөвлөлийн үүрэг ба хариуцлага байхаар, “хэрэгжүүлэх” гэдэгт стратегийн зорилгод хүрэхийн тулд хийж буй үйл ажиллагаануудыг удирдан чиглүүлэх үйл явцыг хамруулан Гүйцэтгэх удирдлагын үүрэг ба хариуцлага байхаар, “хяналт тавих” гэдэгт хэрэгжүүлэлт хэр байгааг хянах үйл явцыг хамруулан Удирдах зөвлөлийн үүрэг ба хариуцлага байхаар тодорхойллоо. Иймд, хэдийгээр засаглал бүх оролцогч талуудын хамтын ажиллагаа байдаг боловч Зорилго 5.1-ийн хүрээнд “Сургуулийн удирдлага” гэдэгт Удирдах зөвлөл ба Гүйцэтгэх удирдлагыг, “Гүйцэтгэх удирдлага” гэдэгт төв захиргаа болон бүрэлдэхүүн, салбар сургуулиудын удирдлагыг багтаав.

Хүснэгт 13. Зорилго 5.1-г хэрэгжүүлэх стратеги, хүрэх үр дүн

ХЭРЭГЖҮҮЛЭХ СТРАТЕГИ	ХҮРЭХ ҮР ДҮН
5.1.1. Сургуулийн удирдлагын засаглал дахь оролцоо, эрх мэдэл, хариуцлагын хүрээг тодорхой болгох	✓ Олон улсын сайн засаглалын жишигт нийцүүлэн чиглүүлэх, хэрэгжүүлэх, хяналт тавих үүрэг хариуцлагыг тодорхой болгож МУИС-ийн дүрэмд шинэчлэлт хийсэн байна.
5.1.2. Удирдах зөвлөлийн бүтцэд хороодыг ажиллуулах	✓ Шаардлагатай хороод байгуулагдаж, сургуулийн удирдлагын стратегийн үйл ажиллагааг чиглүүлэх, хянах явц боловсронгуй болсон байна.
5.1.3. Гүйцэтгэх удирдлагын ажлын ачаалал, үүрэг хариуцлага, үр дүнтэй уялдсан цалин урамшууллын бодлоготой байх	✓ Ажлын ачаалал, үүрэг хариуцлага, үр дүнтэй уялдсан цалин урамшууллын тогтолцоо бүрдэнэ. ✓ Сургуулийн удирдлагын үйл ажиллагаа эрчимжинэ.
5.1.4. Сургуулийн удирдлагыг жендэрийн мэдрэмжтэй, мерит зарчмаар ажиллуулах	✓ Удирдлагын багийн чадамж бэхэжнэ. ✓ Удирдлагын түвшний томилгоо нь жендэрийн мэдрэмжтэй байна.



5.1.5. МУИС-ийн бүтэц, зохион байгуулалтыг оновчтой болгох	✓ Бүрэлдэхүүн болон салбар сургууль, Ахисан түвшний сургуулийн оновчтой бүтэц бүрэлдсэн байна.
--	--

ГҮЙЦЭТГЭЛИЙН ТҮЛХҮҮР ҮЗҮҮЛЭЛТ

- МУИС-ийн засаглал, удирдлагын эрх мэдэл, үүрэг хариуцлага, цалин урамшуулал тодорхойлсон дүрэм журмыг баталж, мөрддөг болсон байна.
- Стратеги төлөвлөгөөний хэрэгжилтэд удирдлагын тогтолцооны түвшин бүрд хариуцлага хүлээдэг байна.
- Бүрэлдэхүүн болон салбар сургууль, Ахисан түвшний сургуулийн оновчтой бүтэц бүрэлдсэн байна.

Зорилго 5.2. Цахим засаглалыг хөгжүүлэх, байгууллагын менежментийн чадамжийг бэхжүүлнэ

МУИС-ийн оролцогч талуудын хоорондох мэдээлэл солилцооны чанарыг сайжруулах, өгөгдөлд суурилсан шийдвэр гарах боломжийг нэмэгдүүлэх, цахим засаглалыг хөгжүүлэх бодлого, эрх зүйн орчныг бүрдүүлж ажиллах хэрэгцээ шаардлага байна. Ингэснээр өгөгдөлд суурилсан бодлого боловсруулах, шийдвэр гаргах хурд нэмэгдэнэ.

Удирдлагын түвшин бүрд төлөвлөлтийн нэгдмэл байдлыг хангаснаар хүний нөөцийн хийж буй үйл ажиллагаа бүр тодорхой зорилгод хүрэх стратегийн хүрээнд хийж буй үйлдэл болж хувирдаг. Иймд нэгжүүдийн богино хугацаат төлөвлөлтийг сургуулийн стратеги төлөвлөгөөтэй уялдуулах чадамжийг хөгжүүлэх, төлөвлөгөөний гүйцэтгэлийн үзүүлэлтүүдийг удирдах албан тушаалтны үр дүнгийн гэрээний хэрэгжилтийг дүгнэх үзүүлэлтүүдтэй холбогдох байдлыг сайжруулснаар стратегийн боловсруулалт хэрэгжүүлэлтийн, өөрөөр хэлбэл стратегийн менежментийн системт үйл явцыг бэхжүүлнэ.

Стратеги төлөвлөгөөний нэн чухал элементүүд нь алсын хараа, эрхэм зорилго, үнэт зүйлс, түүнтэй уялдсан стратегийн тэргүүлэх чиглэлүүд билээ. Сургуулийн дээд удирдлага нь эдгээр элементийг дунд болон анхан шатны менежерүүд, профессор багш, ажилтнууд зэрэг бүх дотоод оролцогч талдаа хэрхэн тайлбарлаж, таниулж байна вэ; дээд удирдлага алсын хараандаа хэр итгэл үнэмшилтэй байж дунд түвшний менежерүүдээ ирээдүйн чиглэлээр, багш, ажилтнуудаа урам зориг эрч хүчээр хангаж байна вэ гэдэгт ач холбогдол өгч ажиллана. Ингэснээр удирдах албан тушаалтнуудын байгууллагын урт хугацааны чиглэлийн талаарх үзэл бодол баттай

хэлбэржиж, стратегич шийдвэр гарч, хүсэмжит байдлыг бодит болгоход гол туслагч болдог байгууллагын гишүүдийн дэмжлэгийг авч байдаг.

Хүснэгт 14. Зорилго 5.2-г хэрэгжүүлэх стратеги, хүрэх үр дүн

ХЭРЭГЖҮҮЛЭХ СТРАТЕГИ	ХҮРЭХ ҮР ДҮН
5.2.1. Дижитал шилжилтийг эрчимжүүлэх	✓ Өгөгдлийн засаглалын тогтолцоог боловсруулж нэвтрүүлсэн байна. ✓ Өгөгдөлд суурилсан нээлттэй, гадаад болон дотоодын хамтын ажиллагаа нэмэгдэнэ. ✓ Мэдээллийн технологийн дэд бүтцийг сайжруулж, хүртээмж нэмэгдсэн байна. ✓ Удирдлага, багш, ажилтан, суралцагчид чиглэсэн дижитал бүтээгдэхүүн, үйлчилгээ нэмэгдсэн байна. ✓ Удирдлага, багш, ажилтны дижитал ур чадвар, өгөгдөлд суурилсан ур чадварыг дээшлүүлсэн байна. ✓ Цаасан суурьтай процессыг дижиталд шилжүүлсэн байна.
5.2.2. Стратегийн төлөвлөлтийн системт үйл явцыг төгөлдөржүүлж, нэгжүүдийн төлөвлөгөө, төсвийг стратеги төлөвлөгөөтэй уялдуулах	✓ Нэгжүүдийн ажлын төлөвлөгөө, төсөв бүр байгууллагын стратегитай уялдаж хэрэгжсэн байна.
5.2.3. Алсын хараа, эрхэм зорилго, үнэт зүйлсийг таниулах, түгээх манлайллыг нэмэгдүүлэх	✓ Стратеги төлөвлөгөөний үндсэн элементүүдийн ойлголт, хэрэглээ нэмэгдэнэ.
5.2.4. Гүйцэтгэлийн менежментийн тогтолцоог бэхжүүлэх	✓ Удирдах албан тушаалтнуудтай байгуулдаг үр дүнгийн гэрээ, түүний хэрэгжилтийг дүгнэх үзүүлэлтүүд стратеги төлөвлөгөөтэй нийцсэн байна.
5.2.5. Байгууллагын үйл ажиллагааны олон улсын ISO 21001-2018 стандартыг нэвтрүүлж, хэрэгжүүлэх	✓ Стандартыг нэвтрүүлсэн байна.



5.2.6. Times Higher Education их дээд сургуулийн зэрэглэл дэх байр сууриа тасралтгүй ахиулах	✓ Times Higher Education зэрэглэл ахисан байна.
5.2.7. МУИС-ийн маркетингийн нэгдсэн бодлого боловсруулж хэрэгжүүлэх	✓ МУИС-ийн үнэт зүйлс, соёл, уламжлалыг таниулж, өвлүүлэх хөтөлбөр хэрэгжсэн байна. ✓ Олон улс болон үндэсний хэмжээнд сургуулийн байр суурь, нэр хүнд нэмэгдэнэ. ✓ Шилдэг элсэгч татна. ✓ Шилдэг хүний нөөц бүрдэнэ. ✓ Оролцогч талуудын эрэлт хэрэгцээнд нийцсэн үйл ажиллагаа төлөвлөгдөж хэрэгжинэ. ✓ Оролцогч талуудын сэтгэл ханамж нэмэгдэнэ. ✓ Цахим хуудасны мэдээ, мэдээллийг монгол, англи хэлээр нийтэлдэг болсон байна.

ГҮЙЦЭТГЭЛИЙН ТҮЛХҮҮР ҮЗҮҮЛЭЛТ

- Өгөгдөлд суурилсан мэдээллийн технологийн дэд бүтэц бүрэлдсэн байна.
- Нэгжүүдийн ажлын төлөвлөгөө, төсөв бүр байгууллагын стратегитай уялдсан байна.
- Үр дүнгийн гэрээг дүгнэх үзүүлэлтүүд байгууллагын стратеги төлөвлөгөөтэй уялдаж хэрэгжсэн байна.
- Байгууллагын үйл ажиллагааны олон улсын стандарт нэвтэрсэн байна.
- Times Higher Education зэрэглэл дэх байраа 100-аар ахиулсан байна.
- Дээд боловсролын сургалтын байгууллагын дотоодын зэрэглэлээр сул үнэлэгдсэн шалгуур үзүүлэлтүүдийг ахиулсан байна.
- Маркетингийн нэгдсэн бодлого хэрэгжсэн байна.

Зорилго 5.3. Стратегийн хэрэгжүүлэлтийн үйл явцыг боловсронгуй болгоно

Стратегийн менежмент нь стратегийн алсын хараа, эрхэм зорилго, үнэт зүйлсийг хөгжүүлэх; зорилгуудыг тодорхойлох; стратегийг бүтээх; стратегийн үр дүнтэй, үр ашигтай хэрэгжүүлэлтийг хангах; хэрэгжилтийн явцыг хэмжиж, гүйцэтгэлийг үнэлж, засаж сайжруулах тохируулгыг хийх гэсэн хоорондоо хэлхээ холбоо бүхий таван үе шатнаас тогтсон, тасралтгүй хөгжиж байдаг үйл явц билээ.

Эхний гурван үе шатыг хамарсан стратегийн төлөвлөлтийн талаар бид багагүй туршлага хуримтлуулсан болно. Харин стратегийн үр дүнтэй, үр ашигтай хэрэгжүүлэлтийг хангах; хэрэгжилтийн явцыг хэмжиж, гүйцэтгэлийг үнэлж, засаж сайжруулах тохируулгыг хийх гэсэн хоёр үе шатны гүйцэтгэлийг сайжруулахад анхаарч ажиллах шаардлага байгаа гэж үзэж энэхүү зорилгыг дэвшүүлэв. Мөн Удирдах зөвлөл, МУИС-ийн ректор, бүрэлдэхүүн, салбар сургуулиудын удирдлагууд МУИС-ийн стратеги төлөвлөгөөнд нийцүүлэн өөрсдийн санхүүгийн болон санхүүгийн бус үйл ажиллагааг ил тод болгож, байнгын давтамжтай байдлаар хараат бусаар ажлаа үнэлдэг, түүнийгээ тогтмол дэлгэрэнгүй тайлагнаж, танилцуулдаг тогтолцоог бий болгоно. Эндээс багш, ажилтан, суралцагч, боловсролын төрийн байгууллага, бусад оролцогч тал нь Удирдах зөвлөлийн гишүүдийн ажил, Ректор, Гүйцэтгэх удирдлага, бүрэлдэхүүн болон салбар сургуулиудын удирдлагуудын ажилд үнэлэлт, дүгнэлт өгөх боломжийг бий болгон ажилладаг болно.

МУИС-ийн сайн засаглалын загварын нэг чухал хэсэг нь нээлттэй ил тод байдал, цаг хугацаандаа байнга тайлагнадаг байдал, оролцогч талуудын байнгын хариуцлага, зарчимч байдал гэсэн олон улсын байгууллагын сайн засаглалын үндсэн зарчмыг ижил мөрдөх нөхцөлийг бүрдүүлнэ.

Хүснэгт 15. Зорилго 5.3-г хэрэгжүүлэх стратеги, хүрэх үр дүн

ХЭРЭГЖҮҮЛЭХ СТРАТЕГИ	ХҮРЭХ ҮР ДҮН
5.3.1. Стратеги төлөвлөгөөний хэрэгжилтэд үнэлгээ, шаардлагатай сайжруулалт хийдэг байх	✓ Стратегийн удирдлагын тогтсон систем бүрдэнэ. ✓ Дүрэм, журмыг шинэчилж, хэрэгжилтэд мониторинг хийдэг болсон байна.
5.3.2. Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн тайлагналын системийн уялдааг хангах	✓ Тайлагналын систем дээр тулгуурлан төлөвлөгөөний хэрэгжилтийн явцад мониторинг үнэлгээ хийнэ. ✓ Стратегийн менежментийн үйл явц сайжирна.
5.3.3. Стратеги төлөвлөгөөний мониторинг, үнэлгээ, сайжруулалт хийх	✓ Стратеги төлөвлөгөөний мониторинг, үнэлгээний нэгжтэй байна. ✓ Стратеги төлөвлөгөөний хэрэгжилтэд 2 жил тутамд үнэлгээ хийсэн байна.



5.3.4. Удирдах зөвлөл болон МУИС-ийн ректор, бүрэлдэхүүн, салбар сургуулийн удирдлага ажлын үр дүнгээ тогтмол хугацаанд тайлагнах	✓ Тайлагнасан үр дүнгийн мэдээллийн сантай болно. ✓ Мэдээлэл холбогдох хууль журмын хүрээнд нийтэд нээлттэй байна.
---	--

ГҮЙЦЭТГЭЛИЙН ТҮЛХҮҮР ҮЗҮҮЛЭЛТ

- Төлөвлөлтийн үзүүлэлтүүдтэй уялдсан тайлагналын загвараар профессор багш, ажилтан, нэгжүүд ажлаа тайлагнасан байдал
- Стратеги төлөвлөгөөний хэрэгжилтэд 2 жил тутамд үнэлгээ хийсэн байна.
- МУИС-ийн Удирдах зөвлөл, ректор, бүрэлдэхүүн, салбар сургуулиудын удирдлагын шийдвэр, ажлын гүйцэтгэл, үр дүнг ил тод, дэлгэрэнгүй нээлттэйгээр тухай бүрд мэдээлж, өгөгдлийн бааз бүрдсэн байдал

ГҮЙЦЭТГЭЛИЙН ТҮЛХҮҮР ҮЗҮҮЛЭЛТ,
ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА

5.1. ГҮЙЦЭТГЭЛИЙН ТҮЛХҮҮР ҮЗҮҮЛЭЛТ

МУИС-ийн хөгжлийн ахиц, дэвшлийг дараах гүйцэтгэлийн түлхүүр үзүүлэлт (KPI)-ээр хэмжих ба одоогийн нөхцөл байдал, 2030 оны зорилго болон завсрын зорилтыг дараах байдлаар тодорхойлж байна. Үүнд:

Хүснэгт 16. Гүйцэтгэлийн түлхүүр үзүүлэлт (суурь, зорилтот түвшин)

№	Гүйцэтгэлийн түлхүүр үзүүлэлт (KPI)	Суурь түвшин	Зорилтот түвшин		
		2023/2024	2026	2028	2030
1	Эрдмийн зэрэгтэй багш нарын нийт багшид эзлэх хувь	59.7%	63%	66%	70%
2	Судалгаа, инновацын ажилд зарцуулж буй төсөв нийт төсөвт эзлэх хувь	5.8%	7%	8%	9.0%
3	Wos, Scopus-т бүртгэлтэй сэтгүүлд хэвлүүлсэн өгүүлэл /тоо/*	WoS-134, Scopus -187	WoS-290, Scopus -420	WoS-420, Scopus -660	WoS-600, Scopus -900
4	Wos, Scopus-ын Q1-Q2 зэрэглэлийн сэтгүүлд хэвлүүлсэн өгүүлэл /тоо/*	89	120	150	180
5	Wos, Scopus-т хэвлүүлсэн өгүүллийн эшлэлийн тооны өсөлт /хувь/*	Wos -2335 Scopus-3953	20%	40%	60%
6	Салбар дундын болон гадаадын судлаачидтай хамтран хэвлүүлсэн өгүүлэл /тоо/*	171	200	250	300



7	Гарааны компани /тоо/*	7	11	15	20
	Патент /тоо/*	54	60	65	70
	Инновацийн бүтээгдэхүүн /тоо/*	5	13	21	30
	Технологийн зүгшрүүлэлт хийсэн бүтээгдэхүүн /тоо/*	1	6	8	10
8	Судалгаа, инновацийн ажлаас жилд олох орлого /тэрбум төгрөг/	5.4	10	15	20
9	Гадаадын санхүүжилттэй судалгааны орлого /тэрбум төгрөг/	2.3	3.0	6.0	8.0
10	Англи хэлээр хэрэгжүүлдэг хөтөлбөр /тоо/*	1	4	7	10
11	Гадаад суралцагчийн нийт суралцагчид эзлэх хувь	4.6%	6%	8%	10%
12	Ахисан түвшний суралцагчдын нийт суралцагчид эзлэх хувь	28.2%	29%	33%	35%
13	Гадаадын сургуульд оюутан солилцоогоор суралцагчийн нийт оюутны тоонд эзлэх хувь	0.4%	0.5%	1%	2%
14	Төгсөгчийн ажил эрхлэлтийн хувь	75.1%	77%	78%	80%
15	Гадаадын профессор багш болон гадаадаас хичээл заах монгол багш, судлаачийн нийт багшид эзлэх хувь	3%	5%	7%	10%
16	Сургалтын бус орлогын нийт орлогод эзлэх хувь	21.5%	30%	35%	40%
17	Нэг багшид ногдох үйлдвэр, аж ахуйн нэгжийн санхүүжилттэй судалгааны орлого /сая төгрөг/	2.3	2.5	3.0	3.5
18	Цахим бүтээгдэхүүн, үйлчилгээний тооны өсөлтийн хувь	25	10%	20%	40%
19	Сургуулийн эзэмшлийн талбайд эзлэх ногоон байгууламжийн хэмжээний өсөлтийн хувь	15,400 м ²	7%	14%	20%

Тайлбар: * Хуримтлагдсан үр дүн

5.2. ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА

Стратегийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд магадалшгүй, урьдчилан тооцоологдоогүй эрсдэл үүсэж болзошгүй ба тэдгээрийн хэрэгжилтийг хянаж, урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах, шаардлагатай үед арга хэмжээ авах хэрэгцээ үүснэ. Иймд тэргүүлэх чиглэл бүрээр стратегийн зорилгуудыг хэрэгжүүлэхэд тулгарах эрсдэлийг төлөвлөн түүнд нийцсэн арга хэмжээг хэрэгжүүлнэ.

Тэргүүлэх чиглэл 1: Эрдэм шинжилгээ – Судалгаа, инновацын чадамжийг бэхжүүлнэ.

Болзошгүй эрсдэлүүд: Судалгаа, инновацын чадамжийг бэхжүүлэх нь сургуулийн тулгуур зорилт боловч дараах эрсдэл үүсэх магадлалтай.

- Нэгдүгээрт, *шаардлагатай санхүү, хөрөнгө оруулалт хийгдэхгүй байх эрсдэлтэй*. Шинжлэх ухаан, инновацын төслүүдийг дэмжихэд төсөв, санхүүгийн нөөц хангалтгүй байснаар судалгааны хамрах хүрээ, чадамж, чадварлаг судлаач багш нарын төвлөрөл үүсэхгүй, цаашлаад санхүүжилт ихээр шаарддаг шинжлэх ухааны салбаруудын хөгжилд сөрөг нөлөөтэй. Санхүүжилт дутагдсанаар судалгааны ажлын чанар, хүртээмж дотоодод болон олон улсын түвшинд сайжрахгүй байж улмаар судалгааны их сургууль болох зорилтыг биелүүлэхэд бэрхшээл үүсгэх юм.
- Хоёрдугаарт, *олон улсын өндөр түвшний судалгааны ажлын тоо нэмэгдэхгүй байх эрсдэлтэй*. Профессор багшийн ажлын үр дүнгийн чухал хэсэг болох улсын өндөр түвшний судалгааны ажлын тоо нэмэгдэхгүй байснаар судалгааны ажлын чанар олон улсад үнэлэгдэх байдал буурч, их сургуулийн олон улсын эрэмбэ дэх судалгаатай холбоотой үзүүлэлтүүд буурна.
- Гуравдугаарт, *судалгаа, инновацаас олох орлого буурах эрсдэлтэй*. Судалгааны орлого өсөхгүй байх нь МУИС-ийн нийт орлогыг олон эх үүсвэрээс бүрдүүлэх зорилтыг биелүүлэхэд сөрөг нөлөөтэй. 70-аас дээш хувийг сургалтын орлого тогтмол эзэлж буй өнөөгийн нөхцөл нь сургуулийн санхүүгийн тогтвортой байдлыг эрсдэлд оруулж байна. Судалгаанаас олох орлого нэмэгдэхгүй нөхцөлд нэг эх үүсвэрээс хараат хэвээр үлдэх нөхцөл байдал цаашид үргэлжлэх болно.
- **Эрсдэлийг удирдах арга зам:** Эрдэм шинжилгээтэй холбоотой эрсдэлүүдийг бууруулахын тулд санхүүжилтийг нэмэх замаар оновчтой хуваарилах тогтолцоог бүрдүүлж, зарим суурь шинжлэх ухааны салбарын судалгааны санхүүжилтийг төрөөс дэмжлэг авах хэлбэрээр тогтвортой үр дүн, хүртээмжтэй санхүүжилтийг хийх



шаардлагатай. Олон улсын өндөр түвшний судалгааны ажлын тоог нэмэгдүүлэхийн тулд профессор багш нарын судалгааны бүтээлийг дэмжих, урамшуулах бодлогыг тууштай баримтлах нь чухал шийдэл болно. Судалгаа, инновацын газар, мэргэжлийн тэнхимүүдийг түшиглэн Scopus-д бүртгэлтэй дотоодын сэтгүүлтэй болохоор төлөвлөгөө гарган ажиллах шаардлагатай. Судалгаанаас олох орлогыг нэмэгдүүлэхийн тулд оролцогч талуудын захиалгаар шинжлэх ухааны олон салбарын судалгааг дотоод нөөц, боломжийг ашиглан хийж гүйцэтгэсэн тоог нэмэхээр олон талт үйл ажиллагаа явуулна.

Тэргүүлэх чиглэл 2: Сургалт – Дэлхийд өрсөлдөх оюунлаг, чадварлаг иргэдийг бэлтгэнэ.

Болзошгүй эрсдэлүүд: Дэлхийд өрсөлдөх чадварлаг мэргэжилтэн, оюунлаг иргэдийг бэлтгэх нь МУИС-ийн гол зорилго бөгөөд үүнд сургалтын чанар, технологийн орчин, хүний нөөцийн асуудал гол эрсдэл болно.

- Нэгдүгээрт, *сургалтын чанар буурах* эрсдэл байна. Хэрэв сургалтын хөтөлбөрүүд хоцрогдсон, дэлхий нийтийн шаардлагад нийцээгүй байвал суралцагчдын боловсролын чанар, өрсөлдөх чадвар буурна.
- Хоёрдугаарт, *сургалтын хэлбэр, технологийн дэд бүтцийн хангалтгүй байдал*. Хэрэв сургалтын технологи, хэлбэр, тоног төхөөрөмж, дэд бүтэц хангалтгүй бол орчин үеийн сургалтын орчинд нийцэхгүй, сургалтын үр өгөөж буурах эрсдэлтэй.

Эрсдэлийг удирдах арга замууд: Эдгээр эрсдэлийг шийдвэрлэхийн тулд МУИС нь сургалтын хөтөлбөрийг олон улсын чиг хандлагад нийцүүлэн шинэчлэх шаардлагатай. Олон улсын стандартад нийцсэн, өрсөлдөх чадвар бүхий сургалтын хөтөлбөрийг боловсруулснаар суралцагчдын мэдлэг, ур чадвар нь дэлхийн түвшинд хүрэх болно. Үүнээс гадна сургалтын технологийн орчныг сайжруулахын тулд орчин үеийн сургалтын хэлбэр, тоног төхөөрөмж, хэрэгслийг нэвтрүүлэх, технологийн дэд бүтцийг хөгжүүлэх нь чухал юм. Энэ нь МУИС-ийн суралцагчдад боловсролын үр өгөөжийг илүү өндөр түвшинд хүргэх боломжийг нэмэгдүүлнэ.

Тэргүүлэх чиглэл 3: Нийгмийн оролцоо – Хамтын ажиллагаагаар нийгэмд тогтвортой үнэ цэнийг бүтээнэ.

Болзошгүй эрсдэлүүд: МУИС нь оролцогч талуудтай хамтарсан нийгмийн оролцоогоор хөгжилд тогтвортой үнэ цэнийг бүтээх боломжтой. Гэвч үүнийг амжилттай хэрэгжүүлэхэд хэд хэдэн эрсдэл үүсэх магадлалтай.

- Нэгдүгээрт, *Нийгмийн үйлчилгээгээр дамжуулан улсын хөгжилд хувь нэмэр оруулах нэгдсэн бодлого, төлөвлөлтгүй байх*. МУИС-ийн хэмжээнд

улсын хөгжилд өөрийн хувь нэмрээ оруулж буй чадварлаг боловсон хүчин олон байдаг боловч тэдгээрийг нэгтгэсэн бодлого байхгүй бол зохион байгуулалт сул, үр дүн багатай үйл ажиллагаа болох юм.

- Хоёрдугаарт, *Тогтвортой хөгжил, байгаль орчинд эсрэг нөлөөллийг үзүүлэх асуудалд оролцдоггүй байдал*. Тогтвортой хөгжил, ногоон ирээдүйг улс орнууд хөгжлийн тэргүүн зорилтуудын нэг хэмээн үзэж буй өнөө цагт МУИС нь үүнийг үйл ажиллагаа, тэргүүлэх чиглэлдээ оруулаагүй байгаа нь Нэгдсэн Үндэстний байгууллагын Тогтвортой хөгжлийн 17 зорилгыг биелүүлэхэд чиглэсэн бодлого, арга хэмжээг авч хэрэгжүүлээгүй байгааг харуулж байна.

Эрсдэлийг удирдах арга замууд: МУИС сургалт, судалгаагаар дамжуулан нийгмийн хөгжилд тасралтгүй хувь нэмрээ оруулж, хөгжлийг түүчээлэгч, соён гэгээрүүлэгч, эерэг, шинжлэх ухаанч хандлагыг тогтмол түгээн дэлгэрүүлж байх шаардлагатай. Эдгээр зүйлсийг үр дүнтэй хийхийн тулд нэгдсэн төлөвлөлтийг гаргаж хийх шаардлагатай. Тогтвортой хөгжил, ногоон ирээдүйг дэмжсэн ажлуудыг үйл ажиллагаандаа нэвтрүүлж, цаашлаад Тогтвортой хөгжлийн зорилгуудын чанартай боловсролыг дэмжих, жендэрийн тэгш байдлыг хангах, хөгжлийн төлөөх түншлэлийг бэхжүүлэх зэрэгт хувь нэмрээ оруулж, тэдгээрийн үзэл санааг нутагшуулах юм.

Тэргүүлэх чиглэл 4: Нөөц – Байгууллагын нөөцийн оновчтой удирдлагыг хөгжүүлнэ.

Болзошгүй эрсдэлүүд: Байгууллагын нөөцийн оновчтой удирдлагыг хангах нь стратегийн амжилтад чухал нөлөөтэй боловч хэд хэдэн эрсдэл тулгарч болно.

- Нэгдүгээрт, *Чадварлаг хүний нөөц дутагдах асуудал үүсэж болзошгүй*. Чадварлаг, туршлагатай боловсон хүчин хангалтгүй байх нь МУИС-ийн сургалт, судалгааны чанар, үр дүнд сөргөөр нөлөөлнө.
- *Хоёрдугаарт, Сурах, ажиллах, хөгжих орчин бүрдүүлэхэд нөөцийн хязгаарлалт үүсэж болзошгүй*. Байгууллагын нөөц хангалтгүй байснаар стратегийн хэрэгжилт удаашрах, тогтвортой байдлыг алдагдуулах эрсдэлтэй.
- Гуравдугаарт, *Орлогын олон талт эх үүсвэр бүрдэхгүй байх эрсдэлтэй*. Сургалтын орлогоос бусад орлогын нийт орлогод эзлэх хувийг нэмэгдүүлэхэд бодитой үйл ажиллагаануудыг систем дараалалтай төлөвлөж хийхгүй бол нэг эх үүсвэрээс орлогын хараат байдал буурахгүй юм.



Эрсдэлийг удирдах арга зам: Эдгээр эрсдэлийг шийдвэрлэхийн тулд МУИС нь санхүүгийн нөөцийг оновчтой удирдах, үр ашигтай зарцуулах арга хэмжээг хэрэгжүүлнэ. Олон эх үүсвэрээс санхүүжилт татах, төсөв хуваарилалтад оновчлол хийх нь санхүүгийн нөөцийг зөв ашиглах боломжийг бүрдүүлнэ. Багш нар нь шинэ мэдлэг, хандлагыг суралцагчдад хүргэх чадвартай байх нь чухал бөгөөд энэ нь сургалтын үр өгөөжийг нэмэгдүүлэхэд чухал нөлөөтэй. Багш нарын чадамжийг нэмэгдүүлэхийн тулд МУИС нь багшлах боловсон хүчний сургалт, хөгжлийг дэмжих хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж, тэдэнд зориулсан дэмжлэг үзүүлэх шаардлагатай. Хүний нөөцийг хөгжүүлэхийн тулд чадварлаг боловсон хүчин бэлтгэх, хөгжүүлэх үйл ажиллагааг дэмжиж, ажилтнууддаа сургалт, дэмжлэг үзүүлэх нь зүйтэй. Мөн тоног төхөөрөмж, хэрэгслийг сайжруулж, техникийн дэд бүтцийг хөгжүүлэх замаар байгууллагын үйл ажиллагааны үр өгөөжийг нэмэгдүүлнэ. Судалгаа, зэргийн бус сургалт болон бусад (сургалтаас гадна) орлогын эх үүсвэрүүдийг нэмэгдүүлсэн шат дараалсан арга хэмжээ авна.

Тэргүүлэх чиглэл 5: Засаглал – Сайн засаглалыг төлөвшүүлж, менежментийн чадамжийг бэхжүүлнэ.

Болзошгүй эрсдэл: МУИС-ийн сайн засаглал, менежментийн чадамжийг бэхжүүлэхэд хэд хэдэн сорилт тулгарна.

- Нэгдүгээрт, *эрх мэдлийн төвлөрөл үүсэх эрсдэлтэй.* Сургуулийн удирдлагын эрх, үүргийн оновчтой бус хуваарилалтаас үүсэлтэй эрх мэдэл хэт нэг газар төвлөрч шийдвэр гаргалтын үйл явцыг удаашруулж, хариуцлагын түвшинд сөргөөр нөлөөлөх магадлалтай.
- Хоёрдугаарт, *ил тод, нээлттэй байдал бий болохгүй байх магадлалтай.* Ил тод байдал хангалтгүй байснаар дотоод оролцогчдын хооронд үл ойлголцол үүсэх эрсдэлтэй.

Эрсдэлийг удирдах арга зам: Эдгээр эрсдэлийг шийдвэрлэхийн тулд ил тод засаглалын зарчим, олон талын оролцоог хангах арга хэмжээг хэрэгжүүлнэ. Шийдвэр гаргалтын үйл явцад ил тод байдал, хяналт тавих замаар хариуцлагыг өндөржүүлнэ. Мөн удирдлагын чадамжийг хөгжүүлэх, сайжруулах зорилгоор сургалт, хөгжлийн хөтөлбөр хэрэгжүүлж, МУИС-ийн удирдлагын үйл ажиллагааны чанарыг дээшлүүлэх нь зүйтэй.

Шийдвэр гаргалтын үр дүнг нэмэгдүүлэхийн тулд удирдлагын үйл ажиллагааг хянах дотоод хяналтын систем нэвтрүүлж, тогтвортой, чанартай засаглалыг бэхжүүлэх боломжтой. Дээрх арга хэмжээнүүдийг хэрэгжүүлснээр МУИС-ийн стратеги төлөвлөгөөг амжилттай хэрэгжүүлж, үүсэж болох эрсдэлүүдийг үр дүнтэй удирдах болно.

“

**МУИС-ИЙН СТРАТЕГИ
ТӨЛӨВЛӨГӨӨ
2025-2030**

**ГҮЙЦЭТГЭЛИЙН
ҮЗҮҮЛЭЛТҮҮД**

”



ХАВСРАЛТ 1

МУИС-ИЙН 2025-2030 ОНЫ СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ
ГҮЙЦЭТГЭЛИЙН НИЙТ ҮЗҮҮЛЭЛТ

(МУИС-ийн 2025-2030 оны стратеги төлөвлөгөөний хүрээнд дэвшүүлсэн
зорилго бүрийн хүрэх үр дүнг хэмжих үзүүлэлтүүд)

№	Гүйцэтгэлийн үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин		
		2023/2024	2026	2028	2030
ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ 1. ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭ					
Зорилго 1.1. Судалгаа, инновацын орчин нөхцөл, чадамжийг сайжруулна					
1	WoS, Scopus-т бүртгэлтэй МУИС-ийн сэтгүүл /тоо/	0	1	1	2
2	Эрдмийн зэрэгтэй багш нарын нийт багшид эзлэх хувь	59.7%	63%	66%	70%
3	Судалгаа, инновацын ажилд зарцуулж буй төсөв нийт төсөвт эзлэх хувь	5.8%	7%	8%	9.0%
4	МУИС-д ажиллах гадаад ба дотоод пост-доктор судлаач /тоо/*	2	10	20	30
5	Гарааны компани /тоо/*	7	11	15	20
	Патент /тоо/*	54	60	65	70
	Инновацын бүтээгдэхүүн /тоо/*	5	13	21	30
	Технологийн зүгшрүүлэлт хийсэн бүтээгдэхүүн /тоо/*	1	6	8	10
6	Судалгааны лаборатори /тоо/*	40	48	57	65
7	Магадлан итгэмжлэгдсэн лаборатори /тоо/	0	1	2	2
Зорилго 1.2. Олон улсын өндөр түвшний эрдэм шинжилгээний ажлуудыг нэмэгдүүлнэ					
8	WoS, Scopus-т бүртгэлтэй сэтгүүлд хэвлүүлсэн өгүүлэл /тоо/*	WoS-134, Scopus -187	WoS-290, Scopus -420	WoS-420, Scopus -660	WoS-600, Scopus -900
9	WoS, Scopus-ын Q1-Q2 зэрэглэлийн сэтгүүлд хэвлүүлсэн өгүүлэл /тоо/*	89	120	150	180



10	Wos, Scopus-т хэвлүүлсэн өгүүллийн эшлэлийн тооны өсөлт /хувь/*	Wos -2335 Scopus-3953	20%	40%	60%
11	Нэг багшид ногдох эшлэлийн тооны өсөлт /хувь/*	WoS: 3.8 Scopus: 6.5	20%	40%	60%
12	Голлох зохиогч нь МУИС-ийн харьяалалтай өгүүллийн нийт өгүүлэлд эзлэх хувь	33%	38%	44%	50%
13	Салбар дундын болон гадаадын судлаачидтай хамтран хэвлүүлсэн өгүүлэл /тоо/*	171	200	250	300
14	Ахисан түвшний суралцагчдын WoS, Scopus-т бүртгэлтэй өгүүлэл /тоо/*	78	120	160	200
15	Судалгаа, инновацийн ажлаас жилд олох орлого /тэрбум төгрөг/	5.4	10	15	20
16	Гадаадын санхүүжилттэй судалгааны орлого /тэрбум төгрөг/	2.3	3.0	6.0	8.0
17	Нэг багшид ногдох үйлдвэр, аж ахуйн нэгжийн санхүүжилттэй судалгааны орлого /сая төгрөг/	2.3	2.5	3.0	3.5
18	МУИС-ийн харьяа судалгааны хүрээлэн, төвүүдийн орлогын өсөлтийн хувь*	1.2 тэрбум ₮	20%	40%	60%
19	Улсын төсвөөс авах судалгааны суурь санхүүжилтийн нийт судалгааны төсөвт эзлэх хувь	0%	6%	13%	20%
20	Багш, суралцагчдын оюуны бүтээлээс олох орлогын өсөлтийн хувь*	13 сая ₮	20%	40%	60%
ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ 2. СУРГАЛТ					
1	Гадаадын их сургуультай хамтарсан хөтөлбөр /тоо/*	5	6	8	10
2	Англи хэлээр хэрэгждэг хөтөлбөр /тоо/*	1	4	7	10



3	Үндэсний хэмжээнд магадлан итгэмжлэгдсэн хөтөлбөрийн нийт хөтөлбөрт эзлэх хувь	18.2%	25%	50%	75%
4	Олон улсын магадлан итгэмжлэгдсэн хөтөлбөр /тоо/*	11	15	18	20
5	Гадаад суралцагчийн нийт суралцагчид эзлэх хувь	4.6%	6%	8%	10%
6	Ахисан түвшний суралцагчдын нийт суралцагчид эзлэх хувь	28.2%	29%	33%	35%
7	Ассистантшип хөтөлбөрт хамрагдсан суралцагч /тоо/	109	140	180	220
8	МУИС-д цагийн хөдөлмөр эрхлэх оюутан /тоо/	305	330	360	400
9	Төгсөгчийн ажил эрхлэлтийн хувь	75.1%	77%	78%	80%
10	Гадаадын сургуульд оюутан солилцоогоор суралцагчийн нийт оюутны тоонд эзлэх хувь	0.4%	0.5%	1%	2%
11	Суралцагчдын сэтгэл ханамжийн дундаж үнэлгээ	88.6%	89%	90%	92%
12	Иж бүрэн цахим хөтөлбөр /тоо/	0	1	3	5
13	Зэргийн бус сургалтын орлогын нийт сургалтын орлогод эзлэх хувь	0.3%	0.5%	1%	2%
14	Англи хэлээр заах хичээл /тоо/	15	30	70	100

ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ 3. НИЙГМИЙН ОРОЛЦОО

1	Хууль, тогтоомж, салбарын бодлого боловсруулалтад оролцсон байдал /хувь/	Суурь түвшин	5%	10%	15%
2	Салбарын болон аж үйлдвэрийн захиалгат төсөлт ажлын өсөлтийн хувь	Суурь түвшин	7%	14%	20%
3	Мэргэжлийн холбоодтой хамтарсан төсөл, хөтөлбөр /тоо/	25	30	40	50



4	Мэдээллийн хэрэгсэл, дижитал сувгаар нийгэмд хүргэсэн контент нэвтрүүлэг /тоо/	16*	30	40	50
5	Оюутны холбоо, клубтэй хамтран нийгэмд чиглэсэн төсөлт ажил /тоо/*	16	20	40	60
6	МУИС-ийн гадаад оюутны холбооны үйл ажиллагаа	-	+	+	+
7	Төгсөгчдийн холбоо, ажил олгогч, төрийн болон бизнесийн байгууллага, холбоод, гадаадын болон олон улсын байгууллага зэрэг оролцогч талуудтай хамтран хэрэгжүүлсэн нийгэмд чиглэсэн төсөлт ажил /тоо/*	5	40	80	120
8	Хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдыг дэмжсэн үйл ажиллагаа /тоо/*	12	15	20	25
9	Сургуулийн эзэмшлийн талбайд эзлэх ногоон байгууламжийг 20 хувиар нэмэгдүүлнэ.	15,400 м ²	7%	14%	20%
10	Ангилж, боловсруулах шатанд хүлээлгэн өгсөн ахуйн хог хаягдлын эзлэх хувийн жин	0	30%	60%	80%
11	Захиргаа, сургалтын үйл ажиллагааны цаасны хэрэглээний бууралт	0	15%	30%	50%
12	Байгаль орчин, нийгэм, засаглал (БОНЗ)-ын тайлан	-	+	+	+
ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ 4. НӨӨЦ					
1	Профессор багш, ажилтны дундаж цалингийн хэмжээ /ам.дол/	800	1000	1300	1600
2	Багш, ажилтныг дэмжих зардлын бакалаврын сургалтын орлогод эзлэх хувь	2.0%	2.5%	2.5%	2.5%
3	Гадаадын профессор багш болон гадаадаас хичээл заах монгол багш, судлаачийн нийт багшид эзлэх хувь	3%	5%	7%	10%



4	Хүний нөөцийг хөгжүүлэх цогц хөтөлбөр хэрэгжсэн байдал	-	+	+	+
5	Шинэчлэгдэн, шинээр ашиглалтад орсон хичээлийн болон бусад барилга, байрууд /тоо/	Суурь түвшин	1	2	3
6	Багш, ажилтанд зориулсан амралтын хэсгийг хичээлийн байр бүрд бий болгоно.	1	4	6	8
7	Мэргэжлийн сурах бичиг, гарын авлагын өсөлт	Суурь түвшин	5%	10%	15%
8	Цахим ном, сурах бичиг /тоо/	900*	1200	1500	2000
9	Цахим бүтээгдэхүүн, үйлчилгээ /хувь/	25	10%	20%	40%
10	Сургалтын бус орлогын нийт орлогод эзлэх хувь	21.5%	30%	35%	40%
11	Эндаумент сангийн өсөлтийн хувь	4,6 тэрбум	20%	40%	60%

ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ 5. ЗАСАГЛАЛ

1	МУИС-ийн засаглал, удирдлагын эрх мэдэл, үүрэг хариуцлага, цалин урамшуулал тодорхойлсон дүрэм журмыг баталж, мөрддөг болно.	-	+	+	+
2	Стратеги төлөвлөгөөний хэрэгжилтэд удирдлагын тогтолцооны түвшин бүрд хариуцлага хүлээдэг байна.	-	+	+	+
3	Бүрэлдэхүүн болон салбар сургууль, Ахисан түвшний сургуулийн оновчтой бүтэцтэй болно.	-	+	+	+
4	Өгөгдөлд суурилсан мэдээллийн технологийн дэд бүтэц бүрэлдэнэ.	-	+	+	+
5	Нэгжүүдийн ажлын төлөвлөгөө, төсөв бүр байгууллагын стратегитай уялдана.	-	+	+	+



6	Үр дүнгийн гэрээг дүгнэх үзүүлэлтүүд байгууллагын стратеги төлөвлөгөөтэй уялдаж хэрэгжүүлнэ.	-	+	+	+
7	Байгууллагын үйл ажиллагааны олон улсын стандарт нэвтэрсэн байна.	-	+	+	+
8	Times Higher Education зэрэглэл дэх байраа 100-аар ахиулна. (1501+)	1987**	1957	1922	1887
9	Дээд боловсролын сургалтын байгууллагын дотоодын зэрэглэлээр сул үнэлэгдсэн шалгуур үзүүлэлтүүдийг ахиулна.	83.5%***	85%	88%	90%
10	Маркетингийн нэгдсэн бодлоготой болж хэрэгжсэн байна.	-	+	+	+
11	Төлөвлөлтийн үзүүлэлтүүдтэй уялдсан тайлагналын загвараар профессор багш, ажилтан, нэгжүүд ажлаа тайлагнадаг байна.	-	+	+	+
12	Стратеги төлөвлөгөөний хэрэгжилтийн үнэлгээ (2 жил тутамд) хийдэг байна.	-	+	+	+
13	МУИС-ийн Удирдах зөвлөл, ректор, бүрэлдэхүүн, салбар сургуулиудын удирдлагын шийдвэр, ажлын гүйцэтгэл, үр дүнг ил тод, дэлгэрэнгүй нээлттэйгээр тухай бүрд мэдээлж, өгөгдлийн баазыг бүрдүүлсэн байна.	-	+	+	+

Тайлбар:

* Хуримтлагдсан үр дүн

** THE2025, National University of Mongolia: Teaching 14.7, Research Environment 9.2, Research Quality 12.5, Industry 20.6, International Outlook 51.0.

*** БШУЯ, Боловсролын үнэлгээний төв, МУИС-ийн үнэлгээ: сургалт 94%, судалгаа 91%, гадаад харилцаа 41%, орчин, үйлчилгээ 73%, нийлбэр үнэлгээгээр 83.5%-иар үнэлэгдэж, 61 их, дээд сургуулиас №1-т эрэмбэлэгдэв.

ХАВСРАЛТ 2

ГҮЙЦЭТГЭЛИЙН ҮЗҮҮЛЭЛТИЙН ТАЙЛБАР

2.1. ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ 1. ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭ – Судалгаа, инновацын чадамжийг бэхжүүлнэ**1. WoS, Scopus-т бүртгэлтэй сэтгүүл**

Web of Science, Scopus мэдээллийн санд бүртгэлтэй сэтгүүлийг хэлнэ.

2. Эрдмийн зэрэгтэй багш нарын нийт багшид эзлэх хувь

Нийт үндсэн орон тооны багшид эзлэх докторын зэрэгтэй үндсэн орон тооны багшийн эзлэх хувийн жинг ойлгоно.

3. Нийт төсөвт судалгаа, инновацын санхүүжилтийн эзлэх хэмжээ

МУИС-ийн төсөвт эзлэх судалгаа, инновацад зарцуулсан нийт зардлын эзлэх хувь хэмжээг хэлнэ.

4. МУИС-д ажиллах гадаад ба дотоод пост-доктор судлаачийн тоо

МУИС-д пост-доктор ажиллуулах журмын 2.1-2.2-д заасан гадаад болон дотоодын судлаачдыг ойлгоно.

5. Амжилттай гарааны компанийн тоо, патентын тоо, инновацын бүтээгдэхүүний тоо, технологийн зүгшрүүлэлт хийсэн бүтээгдэхүүний тоо

Амжилттай гарааны компани: Инновацын бүтээгдэхүүн шинээр үйлдвэрлэх зорилгоор байгуулагдсан, үйл ажиллагаа хэвийн явуулж буй компани.

Патент: Шинэ бүтээл, ашигтай загвар, бүтээгдэхүүний загвар болохыг тодорхойлж, гэрчилгээ авсан бүтээл.

Инновацын бүтээгдэхүүн: Хуулиар тогтоосон шаардлага, нөхцөлийг хангасан, зах зээл дээрх ижил төстэй бүтээгдэхүүн, үйлчилгээнээс техник, эдийн засгийн үзүүлэлт, шинжлэх ухааны багтаамж, нэмүү өртөг бий болгох болон өрсөлдөх чадвараар илүү инновацын үйл ажиллагааны үр дүнд бий болсон бүтээгдэхүүн.

Технологийн зүгшрүүлэлт хийсэн бүтээгдэхүүн: Лабораторийн түвшинд боловсруулсан технологи, бүтээгдэхүүний загварыг үйлдвэрлэлийн нөхцөлд турших, боловсронгуй болгох, технологийн баримтжуулалт хийсэн бүтээгдэхүүн.



6. Судалгааны лабораторийн тоо

МУИС-ийн сургалт, судалгаанд ашиглах тэнхим, төв, нэгжид хамаарах лабораторийг хэлнэ.

7. Магадлан итгэмжлэгдсэн лабораторийн тоо

Дотоод эсвэл гадаадын магадлан итгэмжлэлд хамрагдсан МУИС-ийн лабораторийг ойлгоно.

8. WoS, Scopus-т бүртгэлтэй сэтгүүлд хэвлүүлсэн өгүүллийн тоо

МУИС-ийн нэрээр Web of Science, Scopus-ын мэдээллийн санд бүртгэлтэй сэтгүүлд хэвлүүлсэн өгүүллийн тоо.

9. WoS, Scopus-ын Q1-Q2 зэрэглэлийн сэтгүүлд хэвлүүлсэн өгүүллийн тоо

МУИС-ийн нэрээр WoS болон Scopus-т бүртгэлтэй Q1, Q2 зэрэглэл бүхий сэтгүүлд хэвлүүлсэн өгүүллийг ойлгоно. Өгүүлэлд МУИС-ийн нэрийг дурдсан байна.

10. WoS, Scopus-т хэвлүүлсэн өгүүллийн эшлэлийн тоо

WoS, Scopus-т бүртгэлтэй сэтгүүлд хэвлүүлсэн өгүүллүүдээс эшлэл авагдсан нийт тоог ойлгоно.

11. Нэг багшид ногдох WoS, Scopus-н эшлэлийн тоо

WoS, Scopus-т хэвлүүлсэн өгүүллүүдээс эшлэл авагдсан нийт тоог үндсэн орон тооны багш нарт харьцуулсан утга. Нэг багшид ногдох WoS, Scopus-д хэвлэгдсэн өгүүллийн эшлэлийн тоо жил тутамд 10 хувиар нэмэгдсэн байна.

12. Голлох зохиогч нь МУИС-ийн харьяалалтай байх өгүүллийн нийт өгүүлэлд эзлэх хувь

МУИС-ийн нэрээр голлох зохиогч (нэгдүгээр болон холбоо барих зохиогч)-оор WoS, Scopus-т хэвлүүлсэн өгүүллийн тооны нийт өгүүллийн тоонд эзлэх хувь.

13. Салбар дундын болон гадаадын судлаачидтай хамтран тухайн салбарын дунджаас дээгүүр эрэмбэтэй сэтгүүлд хэвлүүлсэн өгүүллийн тоо

Салбарын дунджаас дээгүүр эрэмбэтэй сэтгүүл гэдэгт WoS, Scopus-т бүртгэлтэй Q1, Q2 ангиллын сэтгүүлийг ойлгоно. МУИС-ийн үндсэн багшийн орон тооны профессор багш нь салбар дундын болон гадаадын судлаачидтай хамтран бичиж хэвлүүлсэн өгүүллийн нийт тоог хэлнэ.

14. Ахисан түвшний суралцагчдын WoS, Scopus-т бүртгэлтэй өгүүллийн тоо

МУИС-ийн магистрант болон докторантуудын WoS, Scopus-т бүртгэлтэй сэтгүүлд хэвлүүлсэн өгүүллийн нийт тоог хэлнэ.



15. Судалгаа, инновацын ажлын орлого

Судалгаа, инновацын хүрээнд МУИС-д орсон нийт орлогыг тооцно.

16. Гадаадын санхүүжилттэй судалгааны орлого

Судалгаа, инновацаас гадаадын санхүүжилтээр МУИС-д орсон орлогын хэмжээгээр тооцно.

17. Нэг багшид ногдох үйлдвэр, аж ахуйн нэгжийн санхүүжилттэй судалгааны орлого

Үйлдвэр, аж ахуйн нэгжийн санхүүжилттэй судалгааны нийт орлогыг үндсэн орон тооны профессор багшийн тоонд харьцуулсан харьцааг хэлнэ.

18. МУИС-ийн харьяа судалгааны хүрээлэн, сургалт, судалгааны төвүүдийн орлого

МУИС-ийн харьяа судалгааны хүрээлэн, төвүүдээс төвлөрүүлсэн нийт орлогын хэмжээ.

19. Улсын төсвөөс авах судалгааны суурь санхүүжилтийн нийт судалгааны төсөвт эзлэх хувь

МУИС-ийн нийт судалгааны төсөвт, улсын төсвийн эх үүсвэртэй судалгааны суурь санхүүжилтийн эзлэх хувийн жинг ойлгоно.

20. Багш, суралцагчдын оюуны бүтээлээс олох орлого

МУИС-ийн багш, суралцагчдын оюуны бүтээл гэдэгт МУИС-ийн нэр дээр бүртгүүлсэн гарааны компани, патент, инновац бүхий бүтээгдэхүүн, технологийн зүгшрүүлэлт хийсэн бүтээгдэхүүнийг хэлнэ. Оюуны бүтээлийн орлого жил тутамд 10 хувиар өссөн байна.

2.2. ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ 2. СУРГАЛТ – Дэлхийд өрсөлдөх чадвартай оюунлаг иргэдийг бэлтгэнэ

1. Гадаадын их сургуультай хамтарсан хөтөлбөрийг тоог 10-д хүргэнэ.

Гадаадын их сургуультай хамтран хэрэгжүүлж буй бакалаврын болон ахисан түвшний сургалтын бүрэн хөтөлбөрийг тооцно.

- МУИС-аас эрэмбэ өндөртэй гадаадын их сургуультай хамтрахыг зорино.
- Хамтарсан хөтөлбөрийг англи хэл болон бусад гадаад хэлээр хэрэгжүүлдэг байж болно.
- Хамтарсан хөтөлбөрийг монгол ба гадаад хэлээр (холимог) хэрэгжүүлдэг байж болно.



- Хөтөлбөрт элсэлт авсан байх шаардлага тавигдана.
- Гадаадын их сургуультай хамтарсан хөтөлбөрийн тоо 2029-2030 оны хичээлийн жилд 10-д хүрсэн байна.
- Хөтөлбөрийн тоог тухайн хичээлийн жилийн 12 болон 6-р сарын байдлаар, мэдээллийн системээс авсан тайлан дахь тоогоор тооцно.

2. Англи хэлээрх хөтөлбөрийн тоог 10-д хүргэнэ.

Англи хэлээр хэрэгжүүлэх бакалаврын болон ахисан түвшний сургалтын бүрэн хөтөлбөрийг тооцно.

- МУИС дангаараа, эсхүл гадаадын их сургуультай хамтран хэрэгжүүлдэг байж болно.
- Англи хэлээрх хөтөлбөрийн тоо 2029-2030 оны хичээлийн жилд 10-д хүрсэн байна.
- Хөтөлбөрийн тоог тухайн хичээлийн жилийн 12 болон 6-р сарын байдлаар, мэдээллийн системээс авсан тайлан дахь тоогоор тооцно.

3. Идэвхтэй хэрэгжиж буй хөтөлбөрийн 75 хувийг үндэсний хэмжээнд магадлан итгэмжлүүлнэ.

Үндэсний хэмжээнд магадлан итгэмжлэгдэж батламж авсан, магадлан итгэмжлэлийн хүчинтэй хугацаа үйлчилж буй бүх түвшний хөтөлбөрийн тоог идэвхтэй хэрэгжиж буй нийт хөтөлбөрийн тоонд харьцуулж тооцно.

- Нийт хөтөлбөрийн тоог гаргахдаа бүрэлдэхүүн, салбар сургуульд хэрэгжиж буй давхацсан хөтөлбөрүүдийг нэгтгэж, мөн мэргэжлийн ба судалгааны магистрын хөтөлбөрийг нэгтгэж тооцно.
- Салбар сургууль дахь хөтөлбөртэй давхцаж буй хөтөлбөрийн хувьд өөрийн үнэлгээний тайлангаа тусдаа бичиж магадлуулсан бол тусдаа тоолж, нэгдсэн байдлаар магадлан итгэмжлүүлсэн бол нэгтгэн тоолно.
- 2029-2030 оны хичээлийн жилд нийт идэвхтэй хэрэгжиж буй хөтөлбөрийн 75 хувь нь үндэсний хэмжээнд магадлан итгэмжлэгдсэн байна.

4. Олон улсад магадлан итгэмжлэгдсэн хөтөлбөрийн тоог 2 дахин нэмэгдүүлнэ.

Олон улсад магадлан итгэмжлэгдсэн хөтөлбөрийн тоог идэвхтэй хэрэгжиж буй нийт хөтөлбөрийн тоонд харьцуулж тооцно.

- Нийт хөтөлбөрийн тоог гаргахдаа бүрэлдэхүүн, салбар сургуульд хэрэгжиж буй давхацсан хөтөлбөрүүдийг нэгтгэж, мөн мэргэжлийн ба судалгааны магистрын хөтөлбөрийг нэгтгэж тооцно.
- 2029-2030 оны хичээлийн жилд олон улсад магадлан итгэмжлэгдсэн хөтөлбөрийн тоо 20-д хүрсэн байна.



5. Гадаад суралцагчийн тоог нийт суралцагчийн 10 хувьд хүргэнэ.

- Сургалтын үндсэн хөтөлбөрт суралцаж буй нийт гадаад суралцагчийн тоог нийт суралцагчийн тоонд харьцуулан тооцно.
- 2029-2030 оны хичээлийн жилд суралцаж буй нийт суралцагчийн 10 хувийг гадаад суралцагч бүрдүүлдэг болно.

6. Ахисан түвшний суралцагчийн тоог нийт суралцагчийн 35 хувьд хүргэнэ.

- Ахисан түвшинд суралцаж буй идэвхтэй суралцагчийн тоог нийт идэвхтэй суралцагчийн тоонд харьцуулж тооцно.
- Идэвхтэй суралцагчийн тоонд танхимын хичээлээ амжилттай судалж дуусгасан, гэрчилгээ авсан суралцагчийг оруулж тооцно.
- 2029-2030 оны хичээлийн жилд идэвхтэй суралцаж буй нийт суралцагчийн 35 хувийг ахисан түвшний суралцагч бүрдүүлдэг болсон байна.

7. Ассистантшип хөтөлбөрт хамрагдсан суралцагчийн тоог 2 дахин нэмэгдүүлнэ.

- Магистрант, докторантыг туслахаар ажиллуулах журмын дагуу ассистантшип хөтөлбөрт хамрагдсан ахисан түвшний суралцагчийн тоог үндэслэн тооцно.
- 2029-2030 оны хичээлийн жилд ассистантшип хөтөлбөрт хамрагдсан суралцагчийн тоог 220 болгон нэмэгдүүлсэн байна.

8. МУИС-д цагийн хөдөлмөр эрхлэх оюутны тоог 400-д хүргэнэ.

- МУИС-ийн бүрэлдэхүүн, салбар сургууль, алба нэгжийн хэмжээнд оюутан ажиллах боломжтой ажлын байранд ажилласан оюутны тоогоор хэмжигдэнэ.
- 2029-2030 оны хичээлийн жилд МУИС-д цагийн хөдөлмөр эрхэлж буй оюутны тоог 400-д хүргэсэн байна.

9. Төгсөгчийн ажил эрхлэлтийг 80 хувьд хүргэнэ.

- Ажил хөдөлмөр эрхэлж буй төгсөгчийн тоог тухайн хичээлийн жилд төгссөн нийт төгсөгчийн тооноос түүвэрлэн, судалгаанд хамрагдсан төгсөгчдийн тоон үзүүлэлтээр тооцно.
- Төгссөний дараагийн хичээлийн жилийн хоёрдугаар улиралд тайланг боловсруулсан байна.

10. Гадаадын сургуульд оюутан солилцоогоор суралцагчийн тоог нийт оюутны 2 хувьд хүргэнэ.

- Тухайн хичээлийн жилд гадаадын их сургуульд оюутан солилцоогоор суралцсан МУИС-ийн суралцагчийн тоог нийт идэвхтэй суралцагчийн тоонд харьцуулж тооцно.



- 2029-2030 оны хичээлийн жилд идэвхтэй суралцаж буй бакалаврын түвшний суралцагчдын 2 хувь нь гадаадын сургуульд оюутан солилцоогоор суралцсан байна.

11. Суралцагчийн сэтгэл ханамжийн дундаж үнэлгээг 92 хувьд хүргэнэ.

- Суралцагчийн сэтгэл ханамжийн дундаж үнэлгээ нь нийт суралцагчдаас хичээлийн жилийн улирал тутам авдаг багш, сургалтын орчин, судалсан хичээлийн талаарх асуулга судалгааны үр дүнгээр тооцогдоно.
- Жилийн эцсийн байдлаарх үнэлгээг 2 улирлын дунджаар гаргана. Санал асуулгын үр дүнг улирал бүрийн төгсгөлд сиси системээс татаж авна.

12. Иж бүрэн цахим хөтөлбөрийн тоог 5-д хүргэнэ.

- Иж бүрэн цахим хөтөлбөрийг Цахим сургалтын журамд заасны дагуу тодорхойлж тооцно.
- 2029-2030 оны хичээлийн жилд иж бүрэн цахим хөтөлбөрийн тоо 5-д хүрсэн байна.
- Хөтөлбөрийн тоог тухайн хичээлийн жилийн 12 болон 6-р сарын байдлаар, мэдээллийн системээс авсан тайлан дахь тоогоор тооцно.

13. Зэргийн бус сургалтын орлогын нийт сургалтын орлогод эзлэх хувийг 2 хувьд хүргэнэ.

- Тухайн хичээлийн жилд зэргийн бус сургалтаас олсон нийт орлогыг МУИС-ийн сургалтын нийт орлоготой харьцуулж тодорхойлно.

14. Англи хэлээр заах хичээлийн тоог 100-д хүргэнэ.

- Сургалт бүхэлдээ англи хэлээр явагдах хичээлийг хамруулан тооцно. Журмын дагуу англи хэлээр хичээл заасан цагийн тооцооны хуудсыг үндэслэнэ.
- 2029-2030 оны хичээлийн жилд англи хэлээр заах хичээлийн тоо 100-д хүрсэн байна.
- Хичээлийн тоог тухайн хичээлийн жилийн 12 болон 6-р сарын байдлаар, мэдээллийн системээс авсан тайлан дахь тоогоор тооцно.

2.3. ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ 3. НИЙГМИЙН ОРОЛЦОО – Хамтын ажиллагаагаар нийгэмд тогтвортой үнэ цэнийг бүтээнэ

1. Боловсруулсан, үнэлэлт дүгнэлт өгч оролцсон хууль тогтоомж, төрийн бодлогын баримт бичгийн тоог 15 хувиар нэмэгдүүлнэ.

МУИС-ийн төлөөлөл оролцсон төрийн бодлого, хууль тогтоомж (хууль тогтоомж - хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийг хамтад нь



нэрлэх ба нийгэм, эдийн засаг, соёлын амьдралд тодорхой дүрэм, журам тогтоох, зохицуулах зорилгоор хууль тогтоох байгууллагаар батлагдсан бичиг баримт; Төрийн бодлогын баримт бичиг- Засгийн газрын түвшинд боловсруулсан, үндэсний стратеги, хууль тогтоомж, хөгжлийн төлөвлөгөөнд чиглэсэн баримт бичиг)-ийн боловсруулалт, хэрэгжилт, үр дүн, нөлөөллийг үнэлэх, сайжруулах чиглэлээр үнэлэлт дүгнэлт гаргах үйл ажиллагааг энд авч үзнэ.

2. Салбарын болон аж үйлдвэрийн захиалгат төсөлт ажлын тоог 20 хувиар нэмэгдүүлнэ.

Салбарын болон аж үйлдвэрийн захиалгат төсөлт ажил гэдэг нь тодорхой салбар буюу аж үйлдвэрийн чиглэлээр тулгамдаж буй асуудлуудыг шийдвэрлэх, шинэчлэх, хөгжүүлэх зорилготойгоор хэрэгжүүлдэг тусгайлан захиалсан төслүүд юм. Эдгээр төслийг ихэвчлэн тухайн салбарын байгууллага, төрийн байгууллага, эсвэл хувийн хэвшлийн компаниуд санаачилж санхүүжүүлдэг.

3. Монгол хэл бичиг, соёл уламжлал, үндэсний дархлааг дэмжихэд чиглэсэн тусгай хөтөлбөр хэрэгжүүлнэ.

Монгол хэл бичиг, соёл уламжлал, үндэсний дархлааг дэмжихэд чиглэсэн тусгай хөтөлбөр нь үндэсний хэл, бичиг, соёл, уламжлалыг хамгаалах, хөгжүүлэх, залуу үед өвлүүлэн уламжлуулах зорилгоор хэрэгжүүлдэг тодорхой зорилт бүхий хөтөлбөр юм. Энэхүү хөтөлбөр нь Монгол Улсын соёлын дархлаа, үндэсний онцлогийг хадгалах, монгол хүн бүрийн бахархлыг сэргээх, олон улсад соёл уламжлалаа сурталчлан таниулах зорилготой.

4. Мэргэжлийн холбоодтой хамтарсан төсөл, хөтөлбөрийн тоо 50-д хүрнэ.

Мэргэжлийн холбоодтой хамтарсан төсөл, хөтөлбөр гэдэг нь их сургууль болон тодорхой салбар, мэргэжлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг мэргэжлийн холбоо, төрийн бус байгууллага болон бусад хуульд заасан статустай байгууллагуудтай хамтран хэрэгжүүлэх үйл ажиллагааг ойлгоно. Тухайн мэргэжлийн чиглэлийн сургалт, судалгаа, зөвлөх үйлчилгээ, оюуны бүтээл гаргах чиглэлтэй.

5. Мэдээллийн хэрэгсэл, дижитал сувгаар нийгэмд хүргэсэн контент нэвтрүүлгийн тоо 50-д хүрсэн байна.

Их сургуулийн шинжлэх ухаанч, эерэг нөлөөлөл бүхий контент, нэвтрүүлэг нь шинжлэх ухааны мэдлэгийг түгээх, эерэг хандлага, нийгмийн хариуцлагыг дэмжихэд чиглэнэ. Эдгээр контент нэвтрүүлэг нь шинжлэх ухааны үндэслэлтэй, баталгаатай мэдлэгийг сонирхолтой, хүртээмжтэй, энгийн хэлбэрээр олон нийтэд хүргэх, иргэдийн



мэдлэгийг нэмэгдүүлэх, тэднийг аливаа асуудалд шинжлэх ухаанч үндэслэлтэй хандахыг дэмжих, соён гэгээрүүлэхэд чиглэсэн, бие даасан шинжтэй ба сошиал медиа, телевиз, радио, эсвэл вэбсайтаар нэвтрүүлнэ. Телевиз, радио нэвтрүүлэг нь 15-60 минут, стандарт нэвтрүүлэг нь 15-30 минут, тусгай нэвтрүүлэг нь 30-60 минут, цуврал нэвтрүүлэг нь 5-10 ангитай, нэг удаад 15-20 минут үргэлжилнэ. Харин сошиал медиа контент нь 1-5 минут байх ба TikTok, Instagram Reels нь 15 секунд - 3 минут, YouTube видео нь 5-20 минут. Энэ тохиолдолд Сошиал медиа контент нь цуврал хэлбэрээр бүтээгдсэн, тодорхой хугацааны давтамжтай мөн зохих хандалтыг авсан байхыг шаардана. Подкаст нь ихэвчлэн 20-60 минут байдаг ч сэдвээс хамаарч урт эсвэл богино байж болно.

Контент, нэвтрүүлгийн төрлүүдийг жишээлэн харуулбал дараах хэлбэртэй байж болно. Үүнд:

Сургалт, лекцийн контент:

Их сургуулийн багш, судлаачдын заасан шинжлэх ухааны лекц, семинаруудыг видео, подкаст хэлбэрээр түгээх. Жишээ: “Ирээдүйн технологи ба бид” цахим контент

Судалгаа, инновацын танилцуулга:

Оюутан, судлаач, багш нарын хэрэгжүүлж буй төслүүд, судалгааны ажлын үр дүнг олон нийтэд хуваалцах. Жишээ: “Залуу судлаачид” видео цуврал.

Нийгмийн ухуулга, эерэг хандлагыг дэмжих нэвтрүүлэг: Байгаль орчны хамгаалал, тогтвортой хөгжил, эрүүл амьдралын хэв маягийг сурталчлах контент. Жишээ: “Эко амьдралын хэв маяг” нэвтрүүлэг.

Оюутнуудын дуу хоолой: Оюутнуудын үзэл бодол, бүтээлч санаачилга, нийгэмд үзүүлэх нөлөөллийг харуулсан подкаст, ярилцлага. Жишээ: “МУИС-ийн оюутан, Монголын ирээдүй: Оюутнуудын санаачилга” подкаст.

Шинжлэх ухааны контент: Хими, физик, биологи, технологи, нийгмийн ухааны сонирхолтой туршилт, мэдээллийг харуулсан богино хэмжээний бичлэг. Жишээ: “Хялбар туршилтууд: Шинжлэх ухааны гайхамшиг” цуврал.

Соёл, уламжлалын контент: Монголын соёл, уламжлал, түүхийг шинжлэх ухааны үндэслэлтэйгээр хөндөх. Жишээ: “Монгол бичгийн гайхамшиг” видео цуврал гэх мэт.

Мэдээллийн хэрэгсэл, дижитал сувгаар нийгэмд хүргэсэн контент нэвтрүүлгийг тооцохдоо төлөвлөгөөний дагуу бүтээгдэж, зохих сувгаар



жигд буюу давтамжтай нэвтрүүлсэн байх мөн тодорхой хандалт авсан байх зэргийг харгалзаж үзнэ.

6. Улс оронд тулгамдсан асуудалд профессор багш нар шинжлэх ухааны үндэслэлтэй тайлбар, зөвлөмжийг олон нийтэд хүргэсэн байна.

Профессор багш нарын шинжлэх ухааны үндэслэлтэй тайлбар, зөвлөмж гэдэг нь бие даасан эсвэл цуврал контент, нэвтрүүлэгтэй харьцуулахад цаг үеийн шинжтэй, нэг удаагийн эсвэл цувралаар хүргэсэн үгэн, зурган, аудио, видео хэлбэртэй мэдээ, баримт юм.

7. МУИС-ийн сургалт, эрдэм шинжилгээ, нийгэмд чиглэсэн онцлох үйл ажиллагааны талаарх мэдээллийг зорилтот бүлгүүдэд түгээнэ.

МУИС-ийн сургалт, эрдэм шинжилгээ, нийгэмд чиглэсэн онцлох үйл ажиллагааны талаарх мэдээлэл гэдэгт сургуулийн орчинд явагдаж буй өдөр тутмын болон онцлог үйл ажиллагааны талаарх агуулга бүхий мэдээллүүдийг (үгэн, зурган, аудио, видео хэлбэртэй) хамруулна.

8. Оюутны холбоо, клубтэй хамтран нийгэмд чиглэсэн 10 төсөлт үйл ажиллагааг жил тутамд хэрэгжүүлсэн байна.

Оюутны холбоо, клубтэй хамтран нийгэмд чиглэсэн төсөлт үйл ажиллагаа нь оюутнуудын нийгмийн хариуцлага, оролцоог нэмэгдүүлэх, нийгэмд эерэг өөрчлөлт авчрах зорилготой тодорхой төсөл, томоохон нөлөө бүхий арга хэмжээнүүдийг хэлнэ. Үүнд оюутнуудын оролцоотой экологи, байгаль хамгаалал, тогтвортой хөгжлийн зорилтуудын чиглэлээр, эрүүл мэндийн зөвлөгөө, хандивын үйл ажиллагаа, боловсролын төсөл, соёл урлагийн арга хэмжээ зэрэг нийгэмд үр дүнтэй байх төслүүд орно. Эдгээр үйл ажиллагаа нь оюутнуудын ур чадварыг хөгжүүлж, нийгмийн асуудлуудыг шийдвэрлэхэд хувь нэмэр оруулах зорилготой.

9. МУИС-ийн гадаад оюутны холбоо байгуулагдаж, үйл ажиллагаа нь тогтмолжсон байна.

Гадаад оюутны холбоо гэдэг нь их сургуулийн гадаад оюутнуудын эрх ашгийг хамгаалах, тэдний сонирхол, хүсэл сонирхлыг төлөөлөх, нийгмийн оролцоог дэмжих зорилгоор байгуулагдсан албан ёсны эсвэл бие даасан байгууллага юм. Оюутны холбоо нь оюутнуудын нийгэм, соёл, боловсролын асуудалд оролцох, тэдний хоорондын харилцаа холбоог сайжруулахад чиглэдэг. МУИС-ийн гадаад оюутны холбоог байгуулж үйл ажиллагааг эрчимжүүлснээр гадаад суралцагч, төгсөгчид болон их сургуулийн харилцаа бэхжин, хамтын ажиллагаа хөгжинө.

10. Төгсөгчдийн холбоо, ажил олгогч, төрийн болон бизнесийн байгууллага, холбоод, гадаадын болон олон улсын байгууллага зэрэг оролцогч



талуудтай нийгэмд чиглэсэн 120 төсөлт үйл ажиллагааг хэрэгжүүлсэн байна.

Нийгэмд чиглэсэн төсөлт үйл ажиллагаа гэдэг нь нийгмийн тодорхой асуудлыг шийдвэрлэх, иргэдийн амьдралын чанарыг сайжруулах, тогтвортой хөгжлийг дэмжих зорилготойгоор хэрэгжүүлдэг төсөл, хөтөлбөр, арга хэмжээнүүдийг хэлнэ. Энэ төрлийн үйл ажиллагаа нь төрийн болон төрийн бус байгууллага, их сургууль, хувийн хэвшил, олон улсын байгууллагуудын санаачилгаар хэрэгждэг бөгөөд олон нийтийн сайн сайхан байдалд эерэг нөлөө үзүүлэхэд чиглэгдсэн байдаг. Төгсөгчдийн холбоо, ажил олгогч, төрийн болон бизнесийн байгууллага, холбоод, гадаадын болон олон улсын байгууллага зэрэг оролцогч талуудтай нийгэмд чиглэсэн төсөлт үйл ажиллагаа нь олон талт хамтын ажиллагааг бий болгож, нийгэмд эерэг өөрчлөлт авчрах зорилготой. Энэ нь оролцогч талуудын нөөц, туршлага, боломжийг ашиглан нийгмийн асуудлуудыг шийдвэрлэх, бүтээмжийг дээшлүүлэх, олон нийтэд үр өгөөжтэй төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэхийг хэлнэ.

11. Хөгжлийн бэрхшээлтэй багш, ажилтан, суралцагчдыг дэмжсэн зорилтот хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн үйл ажиллагааны тоог 25-д хүргэнэ.

Хөгжлийн бэрхшээлтэй багш, ажилтан, суралцагчид, бусад иргэдийг дэмжсэн зорилтот хөтөлбөр нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн боловсрол, ажил эрхлэлт, нийгмийн оролцоог дэмжих, тэдэнд зориулсан тэгш боломжуудыг бүрдүүлэх зорилготой хөтөлбөр юм. Энэ нь тухайн хүмүүсийн тусгай хэрэгцээнд тохирсон тусламж үйлчилгээ, сургалт, дэд бүтцийн сайжруулалт, сурах хөдөлмөрлөх орчныг сайжруулахад чиглэдэг. Энэ хүрээнд төрөл бүрийн үйл ажиллагааг төлөвлөн явуулж болно. Тухайлбал:

Сургалтын орчны тохиргоо:

- Хөгжлийн бэрхшээлтэй багш, суралцагчдын хэрэгцээнд нийцсэн тусгай тоног төхөөрөмж, материал (жишээ нь, харааны бэрхшээлтэй оюутнуудад зориулсан дэлгэц уншигч, дууны хөтөч).
- Сургалтын орчны зохион байгуулалт (өргөн хаалга, цахилгаан шат).

Суралцагчдад зориулсан дэмжлэг:

- Сэтгэлзүйн зөвлөгөө, карьер төлөвлөлт.
- Тусгай хэрэгцээт оюутнуудад зориулсан суралцах аргачлал, хичээлтэй холбоотой менторуудыг томилох.

Ажил эрхлэлтэд дэмжлэг:

- Хөгжлийн бэрхшээлтэй багш, ажилтнуудад тохирсон ажлын байр бий болгох (эргономик сандал, ширээ, технологийн тусламж).



Нийгмийн оролцоог дэмжих:

- Харилцаа холбоог сайжруулах, нийгмийн үйл ажиллагаанд оролцох боломжийг нэмэгдүүлэх.
- Соёл, спортын арга хэмжээнүүдийг зохион байгуулах гэх мэт.

Бусад:

- Тухайн чиглэлээр хүчин төгөлдөр мөрдөгдөж буй Монгол Улсын эрх зүйн баримт бичигт тусгасан бусад үйл ажиллагааг ойлгоно.

12. Сургуулийн эзэмшлийн талбайд эзлэх ногоон байгууламжийг 20 хувиар нэмэгдүүлнэ.

Ногоон байгууламж гэдэг нь байгаль орчныг тэтгэх, сайжруулах зорилгоор мод, бут, зүлэг, цэцэг зэрэг тарьсан болон эко орчин бүрдүүлсэн орон зайн хэсэг юм. Энэ нь агаарын чанарыг сайжруулж, тоосжилтыг бууруулах, гоо зүйн болон экологийн ач холбогдолтой. Үүнийг дараах байдлаар тооцно.

$$\text{Ногоон байгууламжийн эзлэх хувь} = \left(\frac{\text{Ногоон байгууламжийн талбай}}{\text{Нийт талбай}} \right) \times 100$$

13. Ахуйн хог хаягдлыг 80 хувь ангилан ялган, дараагийн боловсруулах шатанд хүлээлгэн өгдөг болно.

Ахуйн хог хаягдлыг ангилан ялган, дараагийн боловсруулах шатанд хүлээлгэн өгөх гэдэг нь сургуулийн хэмжээнд ахуйн орчноос гарч буй хог хаягдлыг зориулалтын дагуу төрөлжүүлэн ангилж, дахин боловсруулах, эсвэл устгах боломжтой хэлбэрээр дамжуулж буй үйл ажиллагааг хэлнэ.

14. Захиргаа, сургалтын үйл ажиллагаанд цахим технологийг нэвтрүүлж, цаасны хэрэглээг 50 хувь бууруулсан байна.

Цахим технологийг нэвтрүүлж, цаасны хэрэглээг бууруулах гэдэг нь орчин үеийн цахим шийдлүүдийг ашиглан цаасны хэрэглээг багасгах үйл явц юм. Энэ нь байгаль орчинд ээлтэй бөгөөд үйл ажиллагааны үр ашгийг нэмэгдүүлэх зорилготой.

15. Сэргээгдэх эрчим хүчний хэрэглээг нэмэгдүүлнэ.

Сэргээгдэх эрчим хүчний хэрэглээ гэж байгальд ээлтэй, сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрээс (нар, салхи, ус, газар доорх дулаан, биомасс гэх мэт) эрчим хүч үйлдвэрлэж хэрэглэхийг хэлнэ. МУИС-д бүртгэлтэй үл хөдлөх болон хөдлөх хөрөнгийг бүхэлд нь эсвэл аль нэг хэсгийн цахилгааны хэрэглээг дээрх арга замаар шийдсэн байхыг ойлгоно.



16. Эрчим хүчний ашиглалтын зардлыг бууруулна.

Эрчим хүчний ашиглалтын зардлыг бууруулах гэдэг нь эрчим хүчийг үр ашигтай ашиглах, алдагдлыг багасгах, шинэ технологиуд болон арга хэлбэрүүдийг ашиглан эрчим хүчний хэрэглээг хэмнэх замаар зардлыг бууруулах явдал юм.

17. Усны хэмнэлтийг бий болгож саарал усны хэрэглээг нэвтрүүлнэ.

Усны хэмнэлтийг бий болгож, саарал усны хэрэглээг нэвтрүүлэх гэдэг нь усыг үр ашигтай зарцуулж, цэвэр усны хэрэглээг багасгахын зэрэгцээ хэрэглээнээс гарсан саарал усыг дахин боловсруулан ашиглах явдал юм. Тухайлбал, ухаалаг усны төхөөрөмж ашигласнаар цэвэр усны хэрэглээг багасгах, шугам хоолой, тоног төхөөрөмжийн эвдрэлээс шалтгаалсан асуудлыг шийдвэрлэснээр усны алдагдлыг бууруулах, багш суралцагчдыг хэмнэлттэй хэрэглээний дадалд сургах зэрэг ажлуудыг энэ хүрээнд зохион байгуулна. Ахуйн хэрэглээнээс гарсан харьцангуй бага бохирдолтой усыг саарал ус гэж нэрлэдэг.

18. Байгаль орчин, нийгэм, засаглал (БОНЗ)-ын тайлан жил бүр гаргана.

Байгаль орчин, нийгэм, засаглалын тайлан нь байгууллагын үйл ажиллагаа, бодлого, шийдвэрүүд нь байгаль орчин, нийгэм, засаглалын чиглэлд хэрхэн нөлөөлж буйг үнэлэх, тайлагнах зорилготой баримт бичиг. Энэ тайлан нь тухайн байгууллага тогтвортой хөгжлийн зорилго болон нийгмийн хариуцлагыг хэрхэн биелүүлж буйг харуулдаг.

2.4. ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ 4. НӨӨЦ – Байгууллагын нөөцийн оновчтой удирдлагыг хөгжүүлнэ

1. Профессор багш, ажилтны дундаж цалинг 2 дахин нэмэгдүүлсэн байна.

- Үндсэн орон тоонд ажиллаж буй профессор багш, ажилтны нийт цалингийн дундаж хэмжээ
- 2024 оны байдлаар дундаж цалин 800 ам.доллар байгааг 2030 онд 1600 ам.доллар болгон нэмэгдүүлсэн байна.
- Монгол банкнаас зарладаг америк долларын тайлант үеийн албан ёсны ханшаар хөрвүүлэн тооцно.

2. Багш, ажилтны хөгжлийг дэмжих үйл ажиллагааны санхүүжилтийг бакалаврын сургалтын орлогын 2.5 хувьд хүргэнэ.

- Багш, ажилтны хөгжлийг дэмжих зардлыг МУИС-ийн багш, ажилтны хөгжлийг дэмжих үйл ажиллагааны санхүүжилтийн журмыг баримтлан тооцно.
- Багш, ажилтны хөгжлийг дэмжих үйл ажиллагааны санхүүжилт нь



2024 оны байдлаар бакалаврын сургалтын орлогын 2.0 хувь байгааг 2030 онд мөн орлогын 2.5 хувьд хүргэнэ.

3. Гадаадын профессор багш болон гадаадаас хичээл заах монгол багш, судлаачийн нийт багшид эзлэх хувийг 10 хувьд хүргэнэ.

- Гадаадын профессор багш болон гадаадын нэр хүндтэй их сургуульд ажиллаж буй монгол багш, судлаачийг МУИС-д давхар харьяалалтай ажиллах боломжийг бүрдүүлнэ. МУИС-ийн үндсэн орон тооны профессор багш гадаадаас ажиллахыг энд тооцохгүй.
- Нийт багшийн тоонд гадаадын профессор багш болон гадаадаас хичээл зааж буй монгол багш, судлаачдын тооны эзлэх хувийг 2030 онд 10 хувьд хүргэнэ.

4. Хүний нөөцийг хөгжүүлэх цогц хөтөлбөр хэрэгжсэн байна.

Профессор багш, ажилтны үндсэн ажил үүргээ үр өгөөжтэй, бүтээмжтэй гүйцэтгэхэд шаардлагатай мэдлэг, ур чадваруудыг тасралтгүй хөгжүүлэх хүний нөөцийн цогц хөтөлбөрийг хэрэгжүүлж үр дүнд хүрсэн байна.

5. Шинэчлэгдэн, шинээр ашиглалтад орсон хичээлийн болон бусад барилга, байруудын тоог 3-аас доошгүй болгоно.

Хичээлийн 3, 6 дугаар байрууд болон МУИС-ийн спорт цогцолборыг шинээр барьж ашиглалтад оруулна. 2030 онд хичээлийн 4 дүгээр байрны шинэ барилгын ажлыг эхлүүлсэн байна.

6. Багш, ажилтанд зориулсан амралтын хэсгийг хичээлийн байр бүрд бий болгоно.

Хичээлийн байр бүрд багш, ажилтанд зориулсан амралтын хэсгийг бий болгож, тохижуулан орчин нөхцөлийг сайжруулсан байдлаар тооцогдоно.

7. Номын сангийн фондод мэргэжлийн сурах бичиг, гарын авлагыг 15 хувь нэмэгдүүлнэ.

Номын сангийн фондод мэргэжлийн сурах бичиг, гарын авлагын тооны эзлэх хувь хэмжээг 15 хувиар нэмэгдүүлнэ.

8. Цахим ном, сурах бичгийн тоог 2000-д хүргэнэ.

Номын сангийн фондод бүртгэлтэй цахим ном, сурах бичгийн тоог 2030 онд 2000-д хүргэнэ.

9. Цахим бүтээгдэхүүн, үйлчилгээний тоо 40 хувиар нэмэгдсэн байна.

- Ашиглагдаж буй мэдээллийн систем, сүлжээ холбооны үйлчилгээг багцалж, цахим бүтээгдэхүүн, үйлчилгээний тоог тооцно. Хэрхэн



багцалсныг доорх хүснэгтэд харуулав. Тухайн бүтээгдэхүүн үйлчилгээнд хамаарах тухайн систем дэх дэд модуль бүрээр тооцохгүй. Жишээ нь, Сургалт удирдлагын мэдээллийн систем нь 20 гаруй дэд модультай.

	Бүтээгдэхүүн/Үйлчилгээ	Хамаарах чиглэл	Холбоо
1	МУИС-ийн цахим хуудас	Байгууллагын үйл ажиллагаа	https://num.edu.mn
	МУИС-ийн бакалаврын өдрийн хөтөлбөрийн элсэлтийн систем	Сургалтын үйл ажиллагаа	https://burtgel.num.edu.mn/bachelor/
2	МУИС-ийн бүртгэлийн нэгдсэн систем	Сургалтын үйл ажиллагаа	https://burtgel.num.edu.mn/negdsen
	МУИС-ийн гадаад иргэний бүртгэлийн систем	Сургалтын үйл ажиллагаа	https://registration.num.edu.mn/
3	Нэгдсэн нэвтрэлт хандлагын систем	Байгууллагын үйл ажиллагаа	https://auth.num.edu.mn/
4	"СИС" сургалт удирдлагын мэдээллийн систем: Ажилтан	Сургалтын үйл ажиллагаа	https://sisi.num.edu.mn/
5	"СИС" сургалт удирдлагын мэдээллийн систем: Багш	Сургалтын үйл ажиллагаа	https://teach-sisi.num.edu.mn/
6	"СИС" сургалт удирдлагын мэдээллийн систем: Суралцагч	Сургалтын үйл ажиллагаа	https://stud-sisi.num.edu.mn/
7	Эрдэм шинжилгээний менежментийн систем	Эрдэм шинжилгээний үйл ажиллагаа	https://research.num.edu.mn/
8	Төслийн удирдлага бүртгэлийн систем	Эрдэм шинжилгээний үйл ажиллагаа	https://project.num.edu.mn/
9	Цахим сургалтын мэдээллийн систем	Сургалтын үйл ажиллагаа	https://online.num.edu.mn/ https://mooc.num.edu.mn/
10	Үнэмлэх бэлтгэх програм	Байгууллагын үйл ажиллагаа	
11	Нээлттэй өгөгдлийн портал	Байгууллагын үйл ажиллагаа	https://data.num.edu.mn/
12	Бүтээлийн хуудар худалгаас сэргийлэх систем	Сургалтын үйл ажиллагаа	https://pds.num.edu.mn/
13	Номын сангийн мэдээллийн систем	Сургалтын үйл ажиллагаа	https://catalog.num.edu.mn/
14	Санхүү, НББ-н программ хангамж	Байгууллагын үйл ажиллагаа	http://finance.num.edu.mn
15	Төсвийн мэдээллийн систем	Байгууллагын үйл ажиллагаа	https://budget.num.edu.mn/
16	Хүний нөөцийн удирдлагын систем	Байгууллагын үйл ажиллагаа	https://hr.num.edu.mn/
17	Албан хэрэг хөтлөлт, бичиг хэргийн программ	Байгууллагын үйл ажиллагаа	https://intranet.gov.mn/
18	Цахим шуудангийн үйлчилгээ	Байгууллагын үйл ажиллагаа	https://portal.office.com/
19	ТУЦ машин үйлчилгээ	Сургалтын үйл ажиллагаа	
20	Систем хооронд өгөгдөл солилцох	Байгууллагын үйл ажиллагаа	https://tree.num.edu.mn/
21	Суралцагчийн карьер хөгжлийг дэмжих үйлчилгээ	Сургалтын үйл ажиллагаа	https://career.num.edu.mn/
22	Сервер үйлчилгээ	Байгууллагын үйл ажиллагаа	
23	Угастай болон угасгүй сүлжээний үйлчилгээ	Байгууллагын үйл ажиллагаа	
24	Дотуур утасны үйлчилгээ	Байгууллагын үйл ажиллагаа	
25	Хяналтын камерийн үйлчилгээ	Байгууллагын үйл ажиллагаа	

- Цахим бүтээгдэхүүн, үйлчилгээний тоо нь 2024 оны байдлаар 25 байгааг 2030 онд 35-д хүргэнэ.

10. Сургалтын бус орлогыг нийт орлогын 40 хувьд хүргэнэ.

- Сургалтын орлогод бакалавр, магистр, докторын сургалт, гадаад оюутны болон ахлах сургуулийн суралцагчийн сургалтын орлогыг багтаана. Сургалтын орлогоос бусад үндсэн үйл ажиллагааны болон туслах үйл ажиллагааны нийт орлогыг сургалтын бус орлого гэнэ.
- Нийт орлогод сургалтын бус орлогын эзлэх хэмжээгээр энэхүү үзүүлэлтийг тооцно.
- Сургалтын бус орлого 2024 оны байдлаар нийт орлогын 21,5 хувийг эзэлж байгааг 2030 онд 40 хувьд хүргэнэ.

11. Эндаумент сангийн хэмжээг 60 хувиар өсгөнө.

Эндаумент санд байршсан мөнгөн хөрөнгийн тоо хэмжээ. Эндаумент сангийн хэмжээ 2024 онд 1 сая ам.доллар байгааг 2030 онд 60 хувиар нэмэгдүүлнэ.

2.5. ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ 5. ЗАСАГЛАЛ – Сайн засаглалыг төлөвшүүлж, менежментийн чадамжийг бэхжүүлнэ

1. МУИС-ийн засаглал, удирдлагын эрх мэдэл, үүрэг хариуцлага, цалин урамшуулал тодорхойлсон дүрэм журмыг баталж, мөрддөг болсон байна.

МУИС-ийн засаглалыг чиглүүлэх, хэрэгжүүлэх, хяналт тавих тогтолцоо гэж авч үзсэн. Байгууллагыг “чиглүүлэх” гэдэгт стратегийг томъёолох, батлах үйл явцыг хамруулан Удирдах зөвлөлийн үүрэг ба хариуцлага байхаар, “хэрэгжүүлэх” гэдэгт стратегийн зорилгод хүрэхийн тулд хийж буй үйл ажиллагаануудыг удирдан чиглүүлэх үйл явцыг хамруулан Гүйцэтгэх удирдлагын үүрэг ба хариуцлага байхаар, “хяналт тавих” гэдэгт хэрэгжүүлэлт хэр байгааг хянах үйл явцыг хамруулан Удирдах зөвлөлийн үүрэг ба хариуцлага байхаар тодорхойлсон. Энэ тогтолцоо ажиллаж, эрх үүргээ биелүүлэх орчныг бүрдүүлэх шаардлагатай.

2. Стратеги төлөвлөгөөний хэрэгжилтэд удирдлагын тогтолцооны түвшин бүрд хариуцлага хүлээдэг байна.

Дээрх орчин бүрдсэнээр менежментийн түвшин бүр стратеги төлөвлөгөөний хэрэгжилтэд хариуцлага хүлээнэ. МУИС-ийн стратеги төлөвлөгөөнд “Сургуулийн удирдлага” гэдэгт Удирдах зөвлөл ба Гүйцэтгэх удирдлагыг, “Гүйцэтгэх удирдлага” гэдэгт төв захиргаа болон бүрэлдэхүүн, салбар сургуулиудын удирдлагыг хамруулсан.

3. Бүрэлдэхүүн болон салбар сургууль, Ахисан түвшний сургуулийн оновчтой бүтэц бүрэлдсэн байна.

Стратегийг хэрэгжүүлэх чухал механизмуудын нэг нь байгууллагын зохион байгуулалтын бүтэц байдаг бөгөөд сонгосон стратегийн хэрэгжүүлэлтийг дэмжсэн зохион байгуулалтын бүтцийг зохиомжлох ёстой.

4. Өгөгдөлд суурилсан мэдээллийн технологийн дэд бүтэц бүрэлдсэн байна. /өгөгдлийн үйлчилгээний тоог 8-д хүргэнэ/

Өгөгдөлд суурилсан мэдээллийн технологийн дэд бүтэц бүрэлдсэн байна.

Өгөгдлийг багцаар нь нийтлэх, дамжуулах, түгээх зэрэг үйл ажиллагаагаар бий болсон үйлчилгээг тоолно.

5. Нэгжүүдийн ажлын төлөвлөгөө, төсөв бүр байгууллагын стратегитай уялдсан байна.

МУИС-ийн стратеги төлөвлөгөөтэй уялдуулан бүрэлдэхүүн болон салбар сургууль, нэгжүүдийн стратеги төлөвлөгөөг боловсруулж албажуулна.



Бүрэлдэхүүн болон салбар сургууль, нэгжүүдийн стратеги төлөвлөгөөнд тулгуурлан тэдгээр нь жил бүр үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулж албажуулна.

6. Үр дүнгийн гэрээг дүгнэх үзүүлэлтүүд байгууллагын стратеги төлөвлөгөөтэй уялдаж хэрэгжсэн байна.

Гүйцэтгэх удирдлагын ажлын үр дүнг үнэлэх үзүүлэлтүүд нь МУИС-ийн стратеги төлөвлөгөөтэй уялдуулан боловсруулж албажуулсан бүрэлдэхүүн болон салбар сургууль, нэгжүүдийн стратеги төлөвлөгөөний гүйцэтгэлийн түлхүүр үзүүлэлтүүд байна.

7. Байгууллагын үйл ажиллагааны олон улсын стандарт нэвтэрсэн байна.

Байгууллагын үйл ажиллагааны олон улсын ISO 21001-2018 стандартыг нэвтрүүлснээр байгууллагын үйл ажиллагаанд төлөвлөлт, зохион байгуулалт, манлайлал, хяналт сайжруулалт гэсэн менежментийн чиг үүргүүд цогцоор хэрэгжих боломж нэмэгдэнэ.

8. Times Higher Education зэрэглэл дэх байраа 100-аар ахиулсан байна.

МУИС-ийн стратеги төлөвлөгөө, түүнтэй уялдуулан боловсруулж албажуулсан бүрэлдэхүүн болон салбар сургууль, нэгжүүдийн стратеги төлөвлөгөөний зорилгууд биелж, гүйцэтгэлийн түлхүүр үзүүлэлтүүдийг хангаж ажилласнаар бид Times Higher Education зэрэглэл дэх байраа ахиулах боломж бүрдэнэ.

9. Дээд боловсролын сургалтын байгууллагын дотоодын зэрэглэлээр сул үнэлэгдсэн шалгуур үзүүлэлтүүдийг ахиулсан байна.

МУИС-ийн стратеги төлөвлөгөө, түүнтэй уялдуулан боловсруулж албажуулсан бүрэлдэхүүн болон салбар сургууль, нэгжүүдийн стратеги төлөвлөгөөний зорилгууд биелж, гүйцэтгэлийн түлхүүр үзүүлэлтүүдийг хангаж ажилласнаар бид Times Higher Education зэрэглэл дэх байраа ахиулаад зогсохгүй, дээд боловсролын сургалтын байгууллагын дотоодын зэрэглэлээр сул үнэлэгдсэн шалгуур үзүүлэлтүүдийг ахиулах боломж бүрдэнэ.

10. Маркетингийн нэгдсэн бодлого хэрэгжсэн байна.

МУИС-ийн маркетингийн нэгдсэн бодлогыг боловсруулж албажуулсан, МУИС-ийн үнэт зүйлс, соёл, уламжлалыг таниулж, өвлүүлэх хөтөлбөр хэрэгжсэн байна. Тус бодлого, хөтөлбөр хэрэгжсэнээр олон улс болон үндэсний хэмжээнд МУИС-ийн байр суурь, нэр хүнд нэмэгдэж, шилдэг элсэгч татаж, шилдэг хүний нөөц бүрдэж, оролцогч талуудын эрэлт хэрэгцээнд нийцсэн үйл ажиллагаа төлөвлөж хэрэгжүүлэн талуудын сэтгэл ханамжийг нэмэгдүүлсэн байна.



11. Төлөвлөлтийн үзүүлэлтүүдтэй уялдсан тайлагналын загвараар профессор багш, ажилтан, нэгжүүд ажлаа тайлагнасан байдал

МУИС-ийн стратеги төлөвлөгөөний хэрэгжилт нь бүрэлдэхүүн болон салбар сургууль, нэгжүүдийн стратеги төлөвлөгөөний хэрэгжилтээр, бүрэлдэхүүн болон салбар сургууль, нэгжүүдийн стратеги төлөвлөгөөний хэрэгжилт нь тэнхим, хэлтэс буюу багш, мэргэжилтнүүдийн төлөвлөгөөт ажлын гүйцэтгэлээр илэрхийлэгдэнэ. Иймд профессор багш, ажилтан удирдлагын түвшин бүрд гүйцэтгэлээ хэрхэн яаж тайлагнах тухайг тодорхойлон албажуулж, түүнийгээ мөрддөг байх ёстой.

12. Стратеги төлөвлөгөөний хэрэгжилтэд 2 жил тутамд үнэлгээ хийсэн байна.

Стратеги төлөвлөгөөний гүйцэтгэлийг үнэлж, засаж сайжруулах тохируулгыг хийх нь стратегийн менежментийн нэг чухал үе шат. Гүйцэтгэлийн тайлагнал дээр үндэслэн стратеги төлөвлөгөөний гүйцэтгэлийг хамгийн багадаа хоёр жил тутам үнэлж дүгнэнэ. Үнэлгээ, дүгнэлтэд тулгуурлан стратегийн менежментийн үе шатуудад, ихэвчлэн хэрэгжүүлэлтийн үйл явцад сайжруулалт хийнэ.

13. МУИС-ийн Удирдах зөвлөл, ректор, бүрэлдэхүүн, салбар сургуулиудын удирдлагын шийдвэр, ажлын гүйцэтгэл, үр дүнг ил тод, дэлгэрэнгүй нээлттэйгээр тухай бүрд мэдээлж, өгөгдлийн бааз бүрдсэн байдал

Ил тод байдлыг хангах нь сайн засаглалын үндсэн зарчмуудын нэг. Иймд сургуулийн удирдлага нээлттэй, ил тод, цаг хугацаандаа тайлагнадаг байдал, хариуцлагатай зарчимч байдлыг удирдлагын шийдвэр, ажлын гүйцэтгэл, үр дүнг мэдээлсэн өгөгдлийн бааз бүрдэлтээр үнэлэх боломжтой.





